

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомж, бусад баримт бичигт заасан эрх хэрэгжүүлж, үүрэг гүйцэтгэх гэрээний хавсралт

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРХОН АЙМАГТ ТӨЛӨӨЛӨН  
2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	2025 оны төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	/мянган төгрөгөөр/	
							Хэрэгжилт хувь	ХШҮ-ний хувь
<b>3.1. Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.</b>								
3.1.1.	Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлж, орон нутагт угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулан, орон нутгийн иргэдийн угийн бичиг хөтлөлтийг зохион байгуулах.	-	Угийн бичгийн хөтлөлтийн хувь	2018 оны судалгаагаар гарсан улсын дундаж үзүүлэлт	-Угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулсан байна. -Угийн бичгийн хөтлөлтийн хувь нэмэгдсэн байна.	Тайлант онд угийн бичиг хөтөлдөг иргэдийн тоо 19.6 хувиар өссөн. Угийн бичиг, удмын түүхийн хөтлөлтийн талаар иргэдийн мэдлэг, ойлголт, оролцоог нэмэгдүүлэх, тэднийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах зорилтын хүрээнд “Уг удам өв соёлын холбоо” НҮТББ-тай хамтран нийт 22 удаагийн төлөвлөгөөт сургалт, нөлөөллийн ажлыг төрийн 7 байгууллага, Баян-Өндөр сумын 26 баг, Жаргалант сумын 3 багийн иргэдэд зохион байгуулж 598 иргэн хамрагдсан. Сургалтаар угийн бичгийн ач холбогдол, удмын мэдээлэл цуглуулах арга зам, архивын тэмдэглэл хөтлөх дадал, угийн зураглал боловсруулах олон төрлийн загварын талаар практик дадлага ажил ажиллуулж, угийн бичиг хөтлөх арга зүйд суралцуулснаар түгээн дэлгэрүүлэх, үр хүүхдэдээ өвлүүлэх, зааж сургах арга хэмжээ нэмэгдсэн.	100%	100%
<b>3.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар:</b>								
3.1.2.1	Гэр бүлийн	24000.0	1.Гэр бүлийн	2024 онд	Орон нутгийн	Цагдаагийн газар гэр бүлийн	100%	100%

	хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;		хүчирхийллийг арилгах чиглэлээр боловсруулсан төлөвлөгөө-1 2.Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн бууралтын хувь	гарсан гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн тоо	гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоож, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснэр гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол, хэрэг, зөрчлийн тоо буурсан байна.	хүчирхийллийн шинжтэй 333 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 57 буюу 17.1 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 276 буюу 82.9 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Гэр бүлийн харилцааг бэхжүүлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 6 чиглэл бүхий төлөвлөгөө боловсруулан 13 байгууллагатай хамтран хэрэгжүүлж, гэр бүлд чиглэсэн 246 удаагийн сургалт, нөлөөллийн ажлыг нийт 11056 иргэнд хүргэсэн. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 8.0 хувиар буурсан. Төлөвлөгөөт ажлын хүрээнд: -“Бүх хайраа гэр бүлдээ” сарын аяны хүрээнд гэр бүлийн өдөрлөг арга хэмжээг зохион байгуулж, өдөрлөгт 3510 гаруй иргэн хамрагдсан. Сарын аяны хүрээнд сэтгэлзүйн өдөрлөг, 12 удаагийн “Хосын харилцаа-өглөөний эвент” уулзалтыг зохион байгуулж 604 иргэн хамрагдсан. -Гэр бүлийн боловсрол, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох газруудтай хамтран “Супер аав”, “Зоригтой хайр”, “Ээж охидын болзоо” уулзалт, “Movie event”, “Жендэрт суурилсан хүчирхийлэл” зэрэг 234 удаагийн сургалт, арга хэмжээнд 2568 хүүхэд, 7884 иргэдийг хамруулсан.		
3.1.2.2.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн	1.Зохион байгуулсан арга хэмжээний тоо 2.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт	2024 онд зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажлын тоо	Сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, хохирогчдод үзүүлэх	Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг өмнөх оны мөн үеэс 8.0 хувиар буурсан. Тайлант онд Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Хүүхэд гэр бүл, хөгжил хамгааллын газрууд хамтран гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж 7–30 хоногийн хугацаатай	100%	100%	

	ажлыг зохион байгуулах.		хэрэг, зөрчлийн бууралтын хувь		үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч, гэмт хэрэг, зөрчил буурсан байна.	баривчлагдсан 100 иргэнээс судалгаа авсан. Судалгаанд оролцогчдын 80.0 хувь нь "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуулийн талаарх мэдлэггүй гэж хариулсан. Иймд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдүүдийн хандлага, ойлголтыг сайжруулах арга хэмжээ авч, танин мэдэхүй, хууль эрх зүй болон хандлага төлөвшүүлэх чиглэлээр долоо хоног бүр ажил зохион байгуулж, нийтдээ 97 удаагийн арга хэмжээнд 196 иргэнийг хамруулсан. Мөн 16 удаагийн сэтгэл зүйн бүлгийн ярилцлага зохион байгуулсан нь оролцогчдын зан үйлийн өөрчлөлтөд эерэг нөлөө үзүүлсэн.		
3.1.2.3.	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг орон нутгийн төсвийн хөрөнгөөр өргөжүүлж, гэр бүлд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсрол олгох;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ авсан гэр бүлийн тоо		Гэр бүлд үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсролын хүртээмж, чанар сайжирна.	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр 20 удаагийн сургалт, бүлгийн зөвлөгөө зохион байгуулж, нийт 27 өрхийн 182 гэр бүлийн 1185 иргэнийг хамруулсан. Үүнд: -"Сэтгэл зүйн цогц боловсрол" ТББ-тай хамтран "Гэр бүлд суурилсан сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх" хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрсдэлийн программд бүртгэлтэй 16 өрхийн 38 хүүхэд, 30 эцэг эхийг хамруулан нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлсэн. -Гэр бүл салалт, хүүхдийн асрамж тогтоохтой холбоотой 7 өрхийн 25 хүүхдэд сэтгэл зүйн оношилгоог хийсэн. Сэтгэл зүйн явуулын үйлчилгээгээр Жаргалант сум, Политехник коллежийн нийт 65 сурагч, оюутанд бүлгийн ярилцлага, 3 хүүхдэд ганцаарчилсан зөвлөгөөг үзүүлсэн. -Эрсдэлийн программд бүртгэлтэй хүүхдүүдэд зориулсан "Би болон бидний ирээдүй" сэтгэл зүйн боловсрол олгох сургалтыг 8 удаагийн давтамжтайгаар Баян-Өндөр сумын Наран, Уртын гол,	100%	100%

						Рашаант, Цагаанчулуут багийн 4 өрхийн 150 иргэнд зохион байгуулж, ганцаарчилсан зөвлөгөөг үзүүлсэн. -- "Тэмүүлэлтэй өсвөр нас", "Өсвөр насны хүүхдийн сэтгэлзүйн аялал" бүлгийн сургалт, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 874 иргэнийг хамруулсан.		
3.1.2.4.	Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж, батлуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Батлагдсан төсөв-100% 2.Зардлын хуваарилалт, үйл ажиллагааны хэрэгжилт 95%-иас дээш түвшинд биелэх	2024 онд баталсан төсөв	Орон нутгийн төсөвт урсгал зардал, үйл ажиллагааны зардал, үйлчилгээний зардлыг 100% тусгаж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар нэмэгдсэн байна.	Орон нутгийн төсвөөс хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний "Түр хамгаалах байр"-ны үйл ажиллагаанд 40.0 сая төгрөг зарцуулсан. Санхүүжилтийг түр хамгаалах байрны өдөр тутмын хэрэглээ, эмчилгээ, хоол хүнс, хамгаалалтын үйлчилгээ зэрэгт зориулалтын дагуу зарцуулсан. Түр хамгаалах байранд нийт 64 үйлчлүүлэгч (57 хүүхэд, 7 насанд хүрсэн хүн) хүлээн авч 5 төрлийн үйлчилгээ үзүүлж, 121 удаагийн хариу үйлчилгээг (давхардсан тоогоор) үзүүлсэн. Мөн хохирогчдыг даван туулагч болгох зорилгоор "Монгол өрх" сэтгэл зүйн хүрээлэн, "Ариунсаруулбат" ТББ-тай хамтран 2 гэр бүлийн 7 хүнд сэтгэл заслын үйлчилгээ үзүүлсэн.	100%	100%
<b>3.1.3. Хүүхдийн эрхийн талаар:</b>								
3.1.3.1.	Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх;	2369056.6	1.Төлөвлөгөө баталсан эсэх 2.Төлөвлөгөө ний хэрэгжилтийн хувь	-	Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад салбар бүрийн оролцоо сайжирсан байна.	Хүүхдийг эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон төрийн бус 26 байгууллагатай хамтарсан 4 чиглэлийн 16 ажлыг төлөвлөн баталж, төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь биелсэн. Төлөвлөгөөний дагуу хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор 57	100%	100%

					<p>удаагийн сургалт, олон талт арга хэмжээг зохион байгуулж, 31422 хүүхэд, 3991 насанд хүрэгчдийг хамруулсан.</p> <p>Тухайлбал:</p> <p>-Цахим орчны хүчирхийлэл, гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, өсвөр насны хүүхдийн архи тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисоос урьдчилан сэргийлэх сургалтыг төрийн байгууллагын 132 ажилтан, ерөнхий боловсролын 23 сургуулийн 9700 сурагчдад зохион байгуулсан.</p> <p>-Үе тэнгийн дээрэлхэлтийн сөрөг нөлөөг бууруулах чиглэлээр “Дээрэлхэж биш, дэмжиж нөхөрлөө”, “Үе тэнгийн дээрэлхэлт ба түүний хор уршиг”, “Харах өнцөгтөө хайр нэмье”, “Нөхөрлөл”, Гэр бүл ба нийгмийн орчин”, “Гэр бүлийн үнэ цэнэ” зэрэг сэдвүүдээр 23 сургуулийн 11680 сурагч, 1930 насанд хүрэгчдэд 35 удаагийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 6 төрлийн 1535 ширхэг гарын авлагыг түгээж, 36 сургууль, цэцэрлэгийн 9321 хүүхдэд “Аврагч мазаалай”, “Гүүмби Жүүмби” видео сургалтыг зохион байгуулсан.</p> <p>-“Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөрийн хүрээнд 19 сургуулийн 1521 сурагчийг сургалтад хамруулсан.“Өсвөрийн сэргийлэгч” явган аялал, дадлага сургуулилтад 200 гаруй сурагч оролцсон бөгөөд ахуйн ослоос урьдчилан сэргийлэх теле хичээлийг орон нутгийн 3 телевиз болон цахим сувгаар олон нийтэд 14000 гаруй хандалттайгаар хүргэсэн. Хүүхэд хүмүүжлийн зэрэг аргын талаар 37 удаагийн сургалтыг зохион байгуулж 1929 насанд</p>	
--	--	--	--	--	---	--

3.1.3.2.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх;		Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь	2024 онд хамрагдсан хүүхдийн тоо	Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо 25 хувиар өссөн байна.	хүрэгчдийг хамруулсан. Хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 22 төрлийн арга хэмжээг зохион байгуулж нийт 11000 хүүхэд хамрагдсан нь нийт хүүхдийн 28.2 хувийг эзэлж байна. Тухайлбал: -“Уран жиргээ-2025” наадмыг ЕБС-ийн бага, дунд, ахлах насны ангилалд зохион байгуулж 3 насны ангилалд нийт 48 хүүхэд оролцсон. -“Бидний Эрдэнэт хот-2045” гар зураг, зохион бичлэгийн уралдааныг зохион байгуулж, зохион бичлэгийн төрөлд 84 хүүхэд, гар зургийн төрөлд 243 хүүхэд тус тус бүтээлээ ирүүлж оролцсон. -ЕБС-ийн “Эко клуб”-үүдэн дунд “Хүрээлэн буй орчин-хүүхдийн оролцоо” сэдэвт төслийн уралдаан зарлаж, нийт 85 хүүхэд оролцсон. -Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан зорилтод өрхийн 5 хүүхдийг өөрсдийнх нь хүсэл сонирхлын дагуу сагсан бөмбөг, япон хэлний сургалтад суралцах хөгжлийн үйлчилгээг үзүүлсэн. -Сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхдүүдийн дунд уламжлалт болон шинэлэг 12 төрлийн уралдаан, тэмцээнийг зохион байгуулж 4000 орчим хүүхэд оролцсон. -Хүүхдийн ордны хүүхэд хөгжлийн дугуйланд 22 дугуйланд 350 хүүхэд, Хангарьд палас, Соёл урлагийн цогцолбор, хувийн хэвшлийн дугуйлан секц зэрэгт 6080 хүүхэд хамрагдсан.	100%	100%
3.1.3.3.	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар		Баталсан төсвийн хэмжээ	2024 онд баталсан төсөв	“Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих	“Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлж	100%	100%

	<p>зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулах;</p>				<p>салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжсэн байна.</p>	<p>ажилласан. Төлөвлөгөөт ажлын хүрээнд 2025 онд бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр 42 СӨББ, ЕБС-иудад сантехник, дулаан алдагдлын иж бүрэн засвар үйлчилгээг хийх 60 гаруй ажилд 15.4 тэрбум төгрөг зарцуулсан. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд харагч, дотуур байрны ажилтан, цэцэрлэгийн багш нарын мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор "Учгийн хэлхээ" ТББ-тай хамтран 30 иргэнийг хамруулсан сургалт зохион байгуулсан. Бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих, хоол тэжээлийн дутагдалд өртөх, өвчлөхөөс сэргийлэхэд хамтын оролцоог хангах ажлын хүрээнд төрийн өмчийн 31 цэцэрлэг нийт 8473 литр сүү, 2500 литр тараг болон хярам, цэлцэгнүүр, ааруулын шүүс, зөөлөн ааруул, сүүтэй өглөөний цай зэргээр үйлчилсэн. "Онч хүүхдүүд" ТББ-тай хамтран бага насны хүүхдийн эрдсийн шинжилгээг хийлгэж сүү цагаан идээний ашиг тусын талаарх мэдээлэл сургалтыг зохион байгуулж, 1584 эцэг эх, асран хамгаалагчид хамрагдсан. СӨББ-уудад "Бодит орчинд суралцъя", "Зугаалга, аялал экскурс" зэрэг ажлуудыг багш, багшийн туслах, эцэг эхийн оролцоотойгоор зохион байгуулж 165 бүлгийн 6720 хүүхдийг хамруулсан. Аймгийн хэмжээнд 2 цэцэрлэг STEAM сургалтын хэрэглэгдэхүүн, 10 цэцэрлэг AR технологи ашиглан бага насны хүүхдийн суралцахуйн хөгжлийг дэмжин ажиллаж байна. "Good Neighbors Mongolia" ОУБ, Орхон аймгийн ЗДТГ, Боловсролын газрын хамтарсан "Бага</p>		
--	---	--	--	--	---	---	--	--

						насны хүүхдийн эрх, хамгааллыг дэмжих төсөл"-ийн хүрээнд төрийн өмчийн 32 цэцэрлэгийн 64 багшийг сургагч багшаар бэлтгэн ахлах 71 бүлэг, бэлтгэл 74 бүлгийн 5600 гаруй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдад мэдээлэл зөвлөгөө өгсөн.		
3.1.3.4.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;		1.Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо 2.Зарцуулсан хөрөнгийн хэмжээ/сая.төг/	-	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100 хувь хангасан байна.	ААНБ-уудын татварын тайлагнах хугацаа нь дараа оны 02 дугаар сарын 10-нд тул одоогоор энэ хөнгөлөлтийн хувь хэмжээ аймгийн хэмжээнд нэгтгэгдэж гараагүй байна.		Хэрэгжилтийг тооцоо хугацаа болоогүй
3.1.3.5.	Аймгийн Хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр танхимаар хангах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах ажиллах;		Байр танхимаар хангасан оролцооны байгууллагын тоо	-	Хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагаа сайжирсан байна.	Аймгийн Засаг даргын 2025 оны А/290 дугаар захирамжаар Хүүхдийн төлөө зөвлөлийг шинэчлэн байгуулж, анхдугаар хурлаар 2025 оны төлөвлөгөөг баталж, 11 үйл ажиллагааг төлөвлөн 100 хувь хэрэгжүүлж ажилласан. -Хүүхдийн оролцоо, өөрийн удирдлагын 85 байгууллагад 1261 хүүхэд хамрагдаж байна. Эдгээр байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэх, нэгдсэн чиглэл, дүрэм, шатлалд оруулах зорилгоор "Зөв ирээдүй-хүүхдийн оролцоо" аймгийн хүүхдийн чуулган зохион байгуулж, 720 төлөөлөгч хүүхэд, 22 хүүхдийн элч, 24 багийн хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан оролцсон. Чуулганы хүрээнд гарсан 23 багц	100%	100%

					<p>саналыг нэгтгэн холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>-Хүүхдийн зөвлөлөөс “Дархлаа”, “Бүх хайраа гэр бүлдээ” рийл, “Эрүүл мэндийн боловсрол” сургалт нөлөөллийн 3 ажил зохион байгуулж 309 хүнийг хамруулсан.</p> <p>-“Өсвөрийн парламент–2025” хөтөлбөрт Орхон аймгаас 6 төлөөлөгч хүүхэд сонгогдож хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээнд Төрийн ордонд оролцсон.</p> <p>-“Хүүхэд-хайр-ирээдүй” Монголын хүүхдийн үндэсний чуулганд аймгийн Хүүхдийн зөвлөлийн 10 төлөөлөгч оролцсон.</p> <p>-Тусгай хэрэгцээт хүүхдэд чиглэсэн “Надад ч бас мөрөөдөл бий” аяныг “Тэгш оролцоо-хязгааргүй боломж” уриан дор өрнүүлсэн ажилласан.</p> <p>-Хүүхдийн оролцооны нийт 26 сургуулиуд дээр зөвлөлүүд байр танхимаар хангагдаж, хүүхдийн оролцооны байгууллагын үйл ажиллагаа сайжирсан үр дүн гарсан.</p>			
3.1.3.6.	“Олон нийтийн байцаагч”-ийг ажиллуулж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх.		1.Олон нийтийн байцаагчийн тоо 2.Илрүүлсэн хүүхдийн тоо	-	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт өмнөх 50 хувиар өссөн байна.	Баян-Өндөр, Жаргалант сумдад хүүхэд хамгаалал хариуцсан “Олон нийтийн байцаагч”-ийг ажиллуулах төсвийг тусгуулахаар санал өгсний дагуу сумууд 2026 оны төсөвт суулгахаар төлөвлөсөн мэдээллийг ирүүлсэн. Тайлант хугацаанд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 452 хүүхдийг илрүүлж, программд бүртгэсэн. Өнгөрсөн онд нийтдээ 956 хүүхэд бүртгэсэн бол тайлант онд онд 452 хүүхдийг нэмж илрүүлэн тайлант хугацаанд илрүүлэлтийг 56.6 хувиар нэмэгдүүлсэн.	100%	100%
<b>3.1.4. Хүүхэд хамгааллын талаар:</b>								
3.1.4.1.	“Хүүхэд хамгааллын	530814.5	Хүүхэд хамгааллын	-	Орон нутгийн хэмжээнд үйл	Төрийн болон хувийн хэвшлийн 121 байгууллага эцэг эхийн зөвлөлтэй, 18	100%	100%

	бодлого"-ыг сурталчлан таниулж, салбар бүрд мөрдүүлэх;		бодлого мөрдсөн байгууллагын тоо		ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн байгууллагын 80 хувьд хүүхэд хамгааллын бодлогыг мөрдүүлсэн байна.	байгууллага хүүхдийн өрөөг бий болгож, 112 байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа нь өмнөх онтой харьцуулахад байгууллагын тоо 17-оор нэмэгдсэн байна. Энэ нь и-оффис программд бүртгэлтэй төрийн болон төрийн өмчийн оролцоотой 120 байгууллагын 93.3 хувь юм. Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд 4 чиглэлээр 60 гаруй байгууллагыг хамруулсан 12 удаагийн сургалтад 192 иргэн хамрагдсан. Аймгийн ИТХ-тай хамтран буддын шашны 10 хийд, христийн шашны 16 сүм, исламын шашны 1 сүм зэрэг нийт 27 сүм, хийдэд хяналт, шалгалт хийж, сүм хийдийн 36 багш, пасторт сургалт зохион байгуулсан. Хариуцлагын гэрээ байгуулсан 27 сүм хийдээс хүүхэд хамгааллын бодлоготой 17, хүүхдийн мэдээллийн сантай 9 сүм хийд байна. Жаргалант сумын ЕБС, Политехник коллеж, Орхон Эмпати сургуулийн дотуур байранд "ЕБС-ийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ – ерөнхий шаардлага MNS 6781:2019" стандартын дагуу хяналт шалгалт хийж, 4 удаагийн сургалт зохион байгуулан 41 багшийг хамруулсан. Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүд төрийн болон хувийн хэвшлийн 24 байгууллагын хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, ажилласан.		
3.1.4.2.	Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын		Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо	-	Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай	Төрийн байгууллагуудын нэгдсэн и-оффис системд 2021 оноос хойш 3696 хүүхдийн 17 төрлийн судалгаа, мэдээллийн бааз бүрдүүлсэн. Тайлант	100%	100%

	үйлчилгээ авсан хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин хүүхдийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх;				хүүхэд бүрд кейс нээж, үйлчилгээг бүрэн хүргэсэн байна.	хугацаанд 452 хүүхдийг шинээр илрүүлж, 42 өрхийн 282 хүүхдэд кейс нээн, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлсэн. Үүнд: -“Сэтгэл зүйн цогц боловсрол” ТББ-тай хамтран “Гэр бүлд суурилсан сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрсдэлийн программд бүртгэлтэй 19 багийн 66 хүүхэд, 40 эцэг эхийг хамруулан нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлсэн. Мөн өндөр эрсдэлтэй 107 өрхийн 297 хүүхдэд эргэн хяналт хийж, эрсдэлийн үнэлгээг дахин шинэчилж 42 өрхийн 107 хүүхдэд кейс нээн ажиллаж байна. 2021-2024 онд үрчлэгдсэн 186 хүүхдийн судалгаанд тодотгол хийж ажиллахад 49% нь хойд эцэгт, 12% эмээ, өвөө, 17% нагац, авгад, 2% нь төрсөн эцэг, эх нь гэрлэлтийн баталгаа авсан, үлдсэн 20% садан төрлийн бус хүмүүст үрчлэгдсэн байна. Үүнээс 152 хүүхэд нь Орхон аймагт амьдарч байгаа, 26 хүүхэд нь Улаанбаатар хот болон бусад аймагт үрчлэгдсэн, 8 хүүхэд насанд хүрсэн байна. Үрчлэгдсэн 152 хүүхдийг мэдээллийн санд бүртгэж, эргэн хяналт хийж, хүүхэд хамгааллын анхан шатны багцын дэмжлэг үзүүлсэн. 2022-2025 онд бүтэн өнчин 76 хүүхэд мэдээллийн санд бүртгэлтэй байгаад эргэн хяналт хийж ажиллаж байна.		
3.1.4.3.	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, шаардлагатай	1.Орон нутгийн төсвөөс хуваарилсан төсөв; 2.Хууль зүйн хорооны үйлчилгээ	26.7 хувь	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд бүрд	Аймгийн Засаг даргын 2024 оны А/878 дугаар захирамжаар Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулсан. Хороо нь 2025 онд 16 ажил төлөвлөснөөс 100% биелсэн. Тайлант хугацаанд хуулийн үйлчилгээнд 46 хүүхэд, эрүүл мэндийн үйлчилгээнд-7, боловсролын үйлчилгээнд-6 хүүхэд	100%	100%	

	зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэх;		авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь		үйлчилгээг бүрэн хүргэсэн байна.	сэтгэл зүйн үйлчилгээнд 19 хүүхэд хамруулж, давхардсан тоогоор 75 удаагийн ганцаарчилсан зөвлөгөө өгсөн байна. Өмгөөллийн үйлчилгээнд 27 хүүхдийг холбон зуучилж 5 төрлийн хууль зүйн үйлчилгээ үзүүлж, орон нутгийн төсвөөс 10.0 сая төгрөг төсөвлөгдсөнийг хуваарийн дагуу зарцуулсан.Тайлант хугацаанд гэмт хэрэгт холбогдсон, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан 28 хүүхдэд хувийн хэрэг нээн бүрдэлт хийн, "Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх журам"-ын дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулсан. Төлөвлөгөөний хүрээнд зан үйлд нөлөөлөх 24 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 672 хүүхдийг хамруулсан. Хөдөлмөрлөх дадал олгох ялаар шийтгүүлсэн 5 этгээдийг цахилгаанчин, авто засварчин, гагнуурчин ангиудад холбон, мэргэжлийн чиг баримжаа олгосон. Үйлчилгээ авах шаардлагатай бүх хүүхдийг 100% хамруулсан.		
3.1.4.4.	Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавих;		1.Хяналт, шалгалтын тоо 2.Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлт ийн хувь	-	Хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдал 95 хувь хангагдсан байна.	Жил бүрийн 11 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаа зохион байгуулахыг хориглосон аймгийн Засаг даргын 2024 оны А/765 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг дарга болон Морин спорт уяачдын холбоодод 4 чиглэл бүхий зөвлөмжийг хүргүүлсэн. Мөн ЗГ-ын 2025 оны 41 дүгээр тогтоолыг зөрчиж уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахгүй байх талаар олон нийтэд хандсан 3 төрлийн постер	100%	100%

						<p>зөвлөмжийг боловсруулан цахим орчинд түгээсэн.</p> <p>2025 оны 05 дугаар сарын 01-ээс 11 дүгээр сарын 01 хүртэлх хугацаанд хурдан морины 5 уралдаан зохион байгуулагдаж, нийт 663 морь уралдаж, 322 хүүхэд оролцсон. Уралдаан тус бүрд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас хүүхдийн бүртгэлийг цахимаар хийж ажилласан. Уралдааны явцад Цагдаагийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, БОЭТ-ийн албан хаагчид уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эрхийг хамгаалах, хамгаалалтын бүрэн хувцас, хэрэглэлтэй оролцуулахад хяналт тавин ажиллаж, стандартын гутал, малгай, мөрөвч, тохойвчгүй хүүхдүүдийг тухай бүрд нь илрүүлэн уяач, морины эзэдтэй холбогдон нэн даруй зөрчлийг арилгуулан, хүүхдийн аюулгүй байдал, эрсдэлийг 100% хангаж ажилласан. Хүүхэд гэмтсэн тохиолдол бүртгэгдээгүй</p>		
3.1.4.5.	Гамшиг, онцгой байдлын үе, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, салбар дундын хүүхэд, хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;		1.Үйлчилгээ авсан өрхийн тоо, хүүхдийн тоо	M№ 6948:2021, Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал. Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг	Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал сайжирсан байна.	Аймгийн хэмжээний нэгдсэн гамшиг онцгой байдлын төлөвлөгөө болон гамшиг онцгой байдлын үед хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөөг тус тус батлан хэрэгжүүлж байна. Тайлант хугацаанд: -124 өрхийн 330 хүүхдэд шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн байна. -Үер, усны аюулд өртөх эрсдэлтэй өрхийн судалгааг гаргаж, нийт 269 хүүхдийг 1 жилийн хугацаатай эрсдэлийн даатгалд хамруулсан. -Угаарын хийх алдах, галын аюул гарах	100%	100%

				шаардлага		<p>эрсдэлтэй нөхцөлд амьдарч байгаа 24 өрхийн 61 хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагч нарыг сургалтад хамруулж хоол хүнс, түлээ нүүрсний дэмжлэг үзүүлсэн.</p> <p>-Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, 54 албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг мэргэжлийн байгууллагаас 1 удаа байгууллагын дотоод сургалтыг 1 удаа тус тус зохион байгуулж ажилласан.</p> <p>-2025 оны гамшгийн нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах" дадлага, сургуулилтад 5-14 насны 9 хүүхэд, 55 насанд хүрэгч (эрэгтэй 11, эмэгтэй 44) аюулгүйн цэгт шилжин ажилласан. Дадлага, сургуулилын бэлтгэл ажлыг хангах зорилгоор тусгай төлөвлөгөө боловсруулан, төлөвлөгөөний дагуу зохион байгуулалттайгаар хэрэгжүүлж албан хаагчдыг дадлагажуулсан.</p> <p>-Мөн гамшиг, онцгой нөхцөл байдлын үед урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд үер, усны аюулд өртөх эрсдэлтэй 100 өрхийн судалгааг гаргаж, нийт 205 хүүхдийг 1 жилийн хугацаатай эрсдэлийн даатгалд хамруулсан</p>		
3.1.4.6.	Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын		Осол гэмтлийн буурсан хувь	-	Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байна.	Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, MNS 6751:2019 "Хүүхдийн тоглоомын талбай–Ерөнхий шаардлага" стандартыг үндэслэн Баян-Өндөр сумын 150 байршил дахь хүүхдийн тоглоомын талбайн эрүүл, аюулгүй орчин, ашиглалтын байдалд үзлэг, шалгалт хийсэн. Шалгалтын үр	100%	100%

	далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, шаардлагатай засвар үйлчилгээг хийх, анхааруулах тэмдэг байршуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх;				<p>дүнд хүүхдийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх, эрсдэл үүсгэж болзошгүй нөхцөл бүхий тоглоом, тоног төхөөрөмжийг илрүүлж, засвар, шинэчлэлт хийх шаардлагатай талаар холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн. Хүүхэд гэмтэж бэртсэн осолдсон дуудлага мэдээлэл бүртгэгдээгүй. Аймаг, сумын хөрөнгө оруулалтаар давхардсан тоогоор 155 тоглоомын талбайд 50.0 сая төгрөгийн засвар үйлчилгээ, сэргээн засварлах ажлыг хийж, сумын хөрөнгө оруулалтаар 3 тоглоомын талбайг шинээр байгуулсан.</p> <p>Хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан тухайн багийн нутаг дэвсгэрийн сургууль, цэцэрлэгийн орчны байдалд эрсдэлийн үнэлгээг хийсэн. Үүнд 15 сургууль, 21 цэцэрлэг хамрагдсан. Мөн БГ, Номын төв, байгууллагын эцэг эхийн зөвлөлүүдэд хичээлийн жил эхлэхтэй холбоотой хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажиллах талаарх зөвлөмж хүргүүлж, зөрчлийг арилгуулсан.</p> <p>Аймгийн хэмжээнд хийгдэж дуусаагүй, 2024 он дамнасан автозам, зогсоол, буудал 13, барилга 5, ИШС 1, 2025 онд ажил гүйцэтгэж дуусаагүй барилга 22, цахилгаан хангамж 64, ИШС 21 барилга засвар 6, автозам зогсоол, буудал 23 зэрэгт ажиллаж байгаа ААНБ-уудад албан шаардлагыг хүргүүлэн ажилласан.</p>		
3.1.4.7.	Хүүхдийн хөгжлийн сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах	Хүүхдийн эрхийн зөрчил буурсан хувь	-	Хүүхдийн эрх зөрчсөн байгууллагын үйл ажиллагааг	Аймгийн хэмжээнд 7 өдөр өнжүүлэх төвд 14 багш ажиллаж, 148 хүүхэд хамрагдаж байна. Үүнээс Тэмүүлэл, Hello joy өдөр өнжүүлэх төвүүд хүүхэд хамгааллын бодлоготой ажиллаж	100%	100%

	<p>үйлчилгээ, сүм хийд, худалдаа үйлчилгээний газар, амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах.</p>				<p>хаах, хязгаарлах арга хэмжээ авч, хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулсан байна</p>	<p>байна. 2025 оны 10 дугаар сард аймгийн хэмжээнд өдөр өнжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 5 төвд нөхцөл байдалтай танилцах, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж, өдөр өнжүүлэх тус бүрд улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн.</p> <p>2025 онд шинээр хүүхэд харах үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан 2 иргэний хүсэлтийн дагуу хяналт хийсэн. Хүүхэд харах үйлчилгээнд “Хүүхэд харах үйлчилгээний шалгуур, болзол, бүрүүлэх баримт бичгийн жагсаалт, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам”-ын 8.1.4 дэх заалтын дагуу 2025 оны 1,4, 10-р саруудад хүүхэд харах үйлчилгээнүүдэд хяналтыг хийж, хүүхэд харах үйлчилгээнд нийт 34.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон.</p> <p>Их дээд болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын төгсөлтийн баяр, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр-хүүхдийн баярыг угтаж, хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, осол гэмтэл, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтууруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр аймгийн ХЭЗХ, ЦГ, БГ, ХГБХХГ хамтран Булган нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 21 амралтын газруудад хяналт шалгалтыг зохион байгуулж, насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт болон хүүхдэд согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх зөвлөмжийг бэлтгэн хүргүүлсэн.</p>		
--	---	--	--	--	--	---	--	--

						Мөн ЕБС, цэцэрлэг, хүүхдийн байгууллагын орчмын дэлгүүрүүдэд хүүхдэд зарж болохгүй хориглосон хүнсний бүтээгдэхүүний жагсаалтаар зөвлөмж бэлтгэн 52 аж ахуй нэгжид хүргэж ажилласан. Аймгийн ИТХ-тай хамтран буддын шашны хийд 10, христийн шашны сүм 16, сламын шашны 1, нийт 27 сүм, хийдээр хяналт шалгалтыг хийж 1 удаагийн сургалтыг сүмийн багш пасторт зохион байгууллаа. 27 сүм хийдтэй хариуцлагын гэрээг шинэчлэн байгуулсан. Сүм, хийдэд нийт 251 хүүхэд хамрагдаж байна.		
<b>3.2.Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана;</b>								
<b>3.2.1.Хөдөлмөрийн харилцааны талаар:</b>								
3.2.1.1.	Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах;	2,237,225.0	Хамрагдсан салбар, ААНБ-ын тоо	Улсын хэмжээнд 2024 онд 17 салбарын 400 иргэн хамрагдсан.	ААНБ, иргэд, олон нийтийн хөдөлмөрийн хууль тогтоомжийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, хуулийн хэрэгжилт сайжирсан байна.	Хөдөлмөрийн тухай хуулийн 43, 46, 78, 79, 80, 99, 100, 101, 109, 144, 145 дугаар зүйлүүдийн талаар зөвлөгөө мэдээллийг 15 иргэн, 12 аж ахуйн нэгж байгууллагад өгсөн. Хөдөлмөрийн тухай хуулиар олон нийтэд тулгамдаж буй зүйл заалтуудаар мэдээлэл бэлтгэн цахим сайтуудаар болон биечлэн хүргэж байна.	100%	100%
3.2.1.2.	Орон нутаг дахь бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ		1.Хамрагдсан ААНБ-ын байгууллагын тоо 2.Зохион	-	Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал,	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 03 дугаар тогтоол, ГБХНХС-ын 2025 оны А/111 "Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж батлах тухай"	100%	100%

	эрхлэгч, ажил олгогчийг дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг дэмжих (хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр)-ийн хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;		байгуулсан сургалтын тоо		эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт сайжирч, хөдөлмөрийн харилцааны соёлыг төлөвшүүлсэн байна.	тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийн хүрээнд “ЭРЖИЭЧ” ХХК, “Эрдэнэт чанар дистрибьюшн” ХХК, “Тэмүүжин оргил” ХХК нийт 3 аж ахуй нэгжийн 75 ажилтанд мэргэшсэн зөвлөх 3.Соёлмаа зөвлөх үйлчилгээ өгч ажилласан. Уг хөтөлбөрийн хүрээнд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч гэрээ, дүрэм, журам, зөвлөмж тус бүрт нь боловсруулж өгсөн. Уг хөтөлбөрийн хүрээнд ХЭДС-аас 9.9 сая төгрөг зарцуулсан.		
3.2.1 3.	Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн арбитр, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;		Хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргааны тоо	Аймгийн хэмжээнд 2024 онд гарсан хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргааны тоо	Хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргаанаас урьдчилан сэргийлж маргааны тоог бууруулсан байна.	Хөдөлмөрийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.6 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хорооны 2022 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны дүрэм”-ийн 2.6 дахь хэсгийг тус тус үндэслэн, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 34 дүгээр тогтоолоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороог 9 үндсэн, 3 орлох гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Тус хороо нь 2024 онд 12, 2025 онд нийт 12 иргэний өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн. 2025 оны өргөдлүүдийг маргааны төрлөөр ангилбал: ✓ Хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсонтой холбоотой маргаан – 6	100%	100%

						<p>✓ Цалин, ээлжийн амралтын хоног, цалин бодолттой холбоотой маргаан – 6</p> <p>Нийт 12 маргааны 3 нь талуудын эвлэрлээр шийдвэрлэгдсэн бол үлдсэн 9 маргаан нь эвлэрэлгүйгээр дууссан байна. Мөн хөдөлмөрийн сонирхлын маргаантай холбоотойгоор арбитрч томилуулах тухай 1 өргөдөл ирсэн бөгөөд хорооны хурлаар уг асуудлыг хэлэлцэж, арбитрч томилоогүй тухай албан тоот хариуг холбогдох иргэнд хүргүүлсэн.</p>		
3.2.1.4.	Аймаг, сумын хамтын хэлэлцээрийг байгуулах, хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулахад санаачилгатай ажиллах.		Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо	Аймгийн хэмжээнд 2024 онд бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо	Хамтын хэлэлцээрийг Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж, бүртгэж, мэдээллийн сан үүсгэсэн байна.	Орхон аймгийн Засаг даргын захирамж, Үйлдвэрчний эвлэлийн болон Ажил олгогч эздийн холбооны тэргүүлэгчдийн 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/829/27/03 тогтоолоор Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны хамтын хэлэлцээр батлагдсан. Хамтын хэлэлцээрийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 27 дугаарт бүртгэсэн. Хөдөлмөр нийгмийн түншлэлийн хамтын хэлэлцээр 2024-2025 онуудад 91.7 хувьтай хэрэгжиж дүгнэгдсэн. Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн дагуу 18 байгууллагын хамтын гэрээг хүлээн авч хянан бүртгэсэнб	100%	100%
<b>3.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар:</b>								
3.2.2.1.	2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний	1067377.5	1. Бодлогын баримт бичгийн тоо, 2. Судалгаа, мэдээллийн тоо	Бүсчилсэн хөгжлийн бодлого Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028	Судалгаа, шинжилгээний ажлыг хийж, шаардлагатай бодлого, үйл ажиллагааны саналыг боловсруулса	Орхон аймгийн хөгжлийн стратеги төлөвлөгөөнд: -Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулах -Уул уурхайн нөхөн сэргээлтийг сайжруулах -Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх Аймгийн Засаг даргын 2025-2028 оны	100%	100%

	<p>салбар, чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийн судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах;</p>			<p>оны хөтөлбөр</p>	<p>н байна.</p>	<p>үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд:  -Зэс боловсруулах, металлурги-химийн үйлдвэр болон бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэр технологийн парк байгуулах  -Сургалт эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор хотхоныг байгуулан шинжлэх ухаанд суурилсан оюуны үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ гэсэн заалтуудыг тусгаж бүсчилсэн хөгжлийн бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллаж байна.  Орон нутгийн төсвийн 50.0 сая төгрөгийн санхүүжилтээр хөдөлмөрийн зах зээлийн судалгааг 2025 оны 09 сарын 30-наас эхлэн Бодлогын шийдэл ТББ, Ногоон эдийн засаг төв ТББ, Харилцааны гайхамшиг ТББ-уудтай хамтран 2025 оны 09 сарын 30-наас эхлэн 3 сарын хугацаатай судалгааг хийж дуусгасан. Судалгааны үр дүнгээр хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн төлөв, байдал тодорхойлогдож, 2030-2035 онуудад эрэлт хэрэгцээтэй байх мэргэжлүүд тодорхойлогдсон.  Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны төсвийн хуваарийн дагуу үйл ажиллагааны арга хэмжээг хэрэгжүүлэхэд 5879 иргэнийг хамруулж 1.9 тэр бум төгрөг зарцуулах чиглэл батлагдсан.  <i>Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд:</i>  -Еjob платформд 357 иргэнийг ажил хайгчаар, 310 ажил олгогч болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдээс 1539 ажил ажлын байрны захиалга</p>	
--	--	--	--	---------------------	-----------------	--	--

					<p>бүртгэж 1002 иргэнийг ажилд зуучилж, шинэ ажлын байранд 1050 иргэнийг бүртгэсэн. -Хөдөлмөр эрхлэлтийн чадварын үнэлгээнд 1027 иргэн, хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөөг 685 иргэн, ажил мэргэжлийн чиг баримжаа зөвлөгөө мэдээллийн ганцаарчилсан үйлчилгээнд 220 иргэн, бүлгийн зөвлөгөө мэдээлэл 573 нийт 5224 иргэн хамрагдсан.</p> <p><i>Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагааны хүрээнд:</i></p> <p>-Суурь ур чадварын сургалтыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны хүрээлэнгээс эрх авсан “Эм эс девелопмент консалтинг” ХХК-ийн сургалтын төвтэй хамтран ажилгүй 35 иргэн, хорих ангид хүмүүжиж байгаа 125 иргэн нийт 160 иргэнд сургалтыг зохион байгуулж 4.5 сая төгрөг зарцуулсан.</p> <p>-Хүн ам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны хүрээлэнгээс зохион байгуулж буй танхимын мэргэжил олгох сургалтыг Орхон Политехникийн коллежтой хамтран 5 мэргэжлээр 48 иргэнийг, мэргэжил олгох сургалтад хамруулж 19.8 сая төгрөгийн сургалтын зардал олгох гэрээ байгуулагдсан.</p> <p>-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн чадамжид суурилсан мэргэжлийн сургалтыг Орхон аймаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн сургалтын төвийн захиалгаар “Уран зангилаа” ХХК-ны дэргэдэх Уран гар сургалтын төвтэй хамтран гар урлал мэргэжлээр 9</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>иргэнийг сургалтад хамруулж сургалтын зардалд 4.4 сая төгрөг, хоол унааны зардал 1.6 сая төгрөг нийт 6.0 төгрөгийг зарцуулсан.</p> <p>-Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээс эрх авсан Эм эс девелопмент консалтинг ХХК-ийн сургалтын төвтэй хамтран санхүүгийн дэмжлэгт хамрагдаж байгаа болон хувиараа хөдөлмөр эрхлэгч 130, хөгжлийн бэрхшээлтэй 40 иргэнийг төсөл бичих 1 өдрийн, бизнесээ хөгжүүлэх 2 өдрийн сургалтад нийт 170 иргэнийг хамруулж сургалтын зардалд 7.6 сая төгрөг зарцуулсан.</p> <p>-Хүн ам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны хүрээлэнгээс зохион байгуулсан ур чадварын цахим сургалтад 13 мэргэжлээр 128 иргэнийг хамруулахаар бүртгэлийг хийж SURGALT.GOV.MN цахим системд баталгаажуулсан. Энэ арга хэмжээнд нийт 338 иргэнийг хамруулсан.</p> <p><i>Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хүрээнд:</i></p> <p>-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг 3 үе шаттайгаар зохион байгуулж арьс шир, эсгий, төмөр, мод модон эдлэл, хүнсний үйлдвэрлэл, оёдол, сүлжмэл, хүнсний хагас боловсруулсан бүтээгдэхүүн, малын дайвар бүтээгдэхүүн, малын тэжээлээр үйлдвэрлэл эрхэлж байгаа</p> <p>-Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 21 иргэнд 197.0 сая төгрөг,</p> <p>-Иргэн, аж ахуй эрхлэгчид олгох</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>санхүүгийн дэмжлэгт 40 иргэнд 400,0 сая төгрөг,          -Залуучуудын "Старт-Ап" аймаг, бүсийн шилдэг гарааны бизнесийн дэмжих санхүүгийн дэмжлэгт 5 багт 82.0 сая төгрөг,          -Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа 20 иргэнд 200.0 сая төгрөг, нийт 86 иргэнд 879.0 сая төгрөгийг 50-100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 5.0-10.0 сая төгрөгийг 24-36 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй санхүүгийн дэмжлэг олгосон. Үүний үр дүнд нийтдээ 86 ажлын байр хадгалагдаж 60 шинэ ажлын байр бий болсон байна.  <i>Түр ажлын байраар хангах болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа:</i>          -Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдах хүсэлт ирүүлсэн 17 байгууллагын 39 ахмад настантай гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнээс 26 иргэн гэрээгээ дүгнүүлж 28.0 сая төгрөгийн урамшуулал авсан. 13 ахмадын гэрээний хугацаа 12 сард дуусаж гэрээгээ дүгнүүлнэ.          -Ахмадын холбоо, Төрийн бус байгууллагын зөвлөх үйлчилгээнд 11 байгууллага хүсэлтээ ирүүлснээс шаардлага хангасан ахмад настны хууль эрх зүй, боловсрол, инженер техникийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ өгөх 7 ТББ-тай 197.9 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж байгаагаас 9.7 сая төгрөгийн эхний санхүүжилтийг олгосон.          -Хүүхдийн эрхийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хүрээнд хүүхэд хамгаалагчаар Цагдаагийн газраас тэтгэвэрт гарсан 2 ахмад настантай</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>гэрээ байгуулан ажиллаж 3 сарын урамшуулал 3.8 сая төгрөгийг олгосон. Түрээсийн дэмжлэг болон борлуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээ:</p> <p>-Түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд жижиг зээл болон санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй 3 иргэнд 3.9 сая төгрөг, жижиг зээлд хамрагдсан 3 иргэнд 4.0 сая төгрөг, иргэнд олгосон санхүүгийн дэмжлэгт 8 иргэнд 14.1 сая төгрөг нийт 14 иргэнд 22.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>-"Эрдэнэт түншлэл 2025" үзэсгэлэн худалдаанд нийт 6 асар түрээслэн авч, санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 14 иргэн өөрсдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ олон нийтэд танилцуулан борлуулсан байна. Санхүүгийн дэмжлэг авсан хувиараа бизнес эрхлэгч 14 иргэн 3 өдрийн хугацаанд өөрсдийн бараа бүтээгдэхүүнийг иргэдэд сурталчилж, борлуулалтын үйл ажиллагаа явуулсны үр дүнд нийт 11.4 сая төгрөгийн борлуулалт хийж, 3.7 сая төгрөгийн үнийн дүн бүхий бараа бүтээгдэхүүний захиалга авсан.</p> <p>-Даниста худалдааны төвд "Эрдэнэтэд үйлдвэрлэв" борлуулалтын цэгийг байгуулж, санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 14 иргэний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг худалдаалж байна. Уг борлуулалтын цэгийн түрээсийн зардалд нийт 7.2 сая төгрөг зарцуулсан.</p> <p>-"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа" хөтөлбөр болон нэгдсэн удирдамжийн хүрээнд хэрэгжүүлэх</p>	
--	--	--	--	--	---	--

						ажлыг олон нийтэд танилцуулах, мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор бүсчилсэн өдөрлөгүүдийг зохион байгуулж, иргэдэд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бодлого, шийдвэрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, мэргэжлийн зөвлөгөө хүргэлээ. Өдөрлөгт нийт 679 иргэн идэвхтэй хамрагдсан байна. Мөн 2025 оны 5, 9 саруудад “Хөдөлмөрийн өдөрлөг”-ийг зохион байгуулж, ажил олгогч болон ажил хайгч иргэдийн уулзалт, ажлын байрны талаар мэдээлэл зөвлөгөөг 400 гаруй иргэнд өгч ажилласан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд нийтдээ 1756 иргэн хамрагдаж 1.1 тэрбум төгрөг зарцуулсан.		
3.2.2.2.	Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж, шинээр бий болох ажлын байр, ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг нарийвчлан тооцож, хэрэгцээтэй хүний нөөцийн тоо мэдээг салбар, мэргэжил бүрээр гаргах;		Судалгаа, мэдээллийн тоо	1.Албан ёсны статистик (Ажиллах хүчний судалгаа) 2.Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний мэдээллийн сан (ЕЛЭВ систем)	Аймгийн /сум тус бүрээр/ ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын тоон мэдээллийн чанар сайжирч, судалгаа, бүртгэл мэдээллийн сан үүссэн байна.	Аймгийн Засаг даргын 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн А/225 дугаар захирамжаар Орхон аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт болон үр дүнгийн тоон болон чанарын судалгаа зохион байгуулах Ажлын хэсэг байгуулагдсан. Аймгийн 2025 оны төсвийн тодотголоор хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хийх 50.0 сая төгрөгийг батлуулж, 2025 оны 09 сарын 30-наас эхлэн Бодлогын шийдэл ТББ, Ногоон эдийн засаг төв ТББ, Харилцааны гайхамшиг ТББ-уудтай хамтран 2025 оны 09 сарын 30-наас эхлэн 3 сарын хугацаатай судалгааг хийж дуусгасан. Судалгааны дүнг 2025 оны 12 дугаар сарын 09-нд аймаг орон нутгийн удирдлагуудад танилцуулж, нийтэд мэдээлсэн.	100%	100%
3.2.2.3.	Орон нутгийн хүн амын бүлгүүд (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд,		1.Аймгийн ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөр	1.Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын	Хүн амын бүлэг тус бүрээр судалгаа	Нийгмийн бүлгүүдээс хүн амын бүлэг болох хүүхэд гэр бүл, эрэгтэй эмэгтэйчүүд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон	70%	70%

	<p>ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан залуучууд зэрэг)-ийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдлын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, онцлог, хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p>		<p>эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн тооны өсөлт, бууралтын хувь 2.Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн тооны өсөлтийн хувь</p>	<p>үзүүлэлтийн гүйцэтгэл 1.2023 он - Ажиллах хүчний оролцооны түвшин улсын хэмжээнд 59.5%, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 56.3%, ажилгүйдлийн түвшин 5.3% 3.2022 он - ядуурлын түвшин хөдөө 35.6%, аймгийн төв 26.1%, сумын төв 30.6%, хөдөө нутаг 41.2%</p>	<p>хийгдэж, бүртгэл мэдээллийн сан үүсч, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.</p>	<p>тэдгээрт төрийн үйлчилгээг үзүүлэх боловсрол, эрүүл мэнд, соёл, спорт, хөдөлмөр нийгмийн хамгаалал нийгмийн салбаруудын хүний нөөцийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх үндсэн зорилго бүхий "Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийг боловсруулж аймгийн ИТХ-ын 2025 оны 02/16 тогтоолоор батлуулан хэрэгжүүлж эхэлсэн. Хөтөлбөр батлуулахтай холбогдуулан хүн амын бүлгүүдийн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр үндсэн хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хэрэгжилтэд үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 65 арга хэмжээ бүхий төлөвлөгөө баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 754.0 сая төгрөгийг зарцуулсан. Баян-Өндөр, Жаргалант сумдын нийт 29 багаас хөдөлмөр эрхлэлтийн судалгааг авахад судалгаанд хамрагдсан нийт 7483 иргэнээс 6132 нь ажилгүй, 466 нь ажилгүйдэлд өртөж болзошгүй, 885 нь ажил олоход хүндрэлтэй иргэн хэмээн бүртгэгдсэн. Судалгаанд хамрагдсан иргэдээс 128 иргэнийг Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтад хамруулсан. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 47.9, ажиллах хүчний оролцооны түвшин 55.6, ажилгүйдлийн түвшин 13.9, ядуурлын хамралтын хүрээ хангайн бүсэд 33.5% /2022/-тай байна.</p>		
3.2.2.4.	Нийгмийн халамжийн		1.Нийгмийн халамж	2023 он ДНБ-д	Аймгийн хэмжээнд	Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа болон Нийгмийн	100%	100%

	дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох, дэмжих замаар халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хэрэгжилтийг хангуулах;		авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо 2.Холбогдох арга хэмжээний тоо 3.Төлөвлөсөн зарцуулсан хөрөнгийн хэмжээ	нийгмийн тусламжийн зардлын эзлэх хувийн жин 3.7%, /2023 он/	халамжаас хөдөлмөрт шилжих бодлого бодитой хэрэгжиж, хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдсэн байна.	дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай зорилтод өрхийн 54 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 74 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад 80 иргэнийг хамруулж зөвлөгөө мэдээлэл өгсөн. Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 10 иргэн хамрагдсан. Мэргэжил олгох сургалтад 19 иргэн бүртгүүлсэн.Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн түвшин өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 47.9 болж 4.9 пунктээр өссөн байна.		
3.2.2.5.	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв (job center)-ийг орон нутагт нээн ажиллуулах, дэмжлэг үзүүлэх;		1.Ажилд зуучлуулсан иргэний тооны өсөлт 2.Холбогдох арга хэмжээний тоо	-	Аймгийн хэмжээнд албан бусаас албан хөдөлмөрт шилжин ажиллагсдын тоо нэмэгдсэн байна.	Монголын Хүний нөөцийн менежментийн холбооны дэргэдэх хувийн хөдөлмөрийн биржтэй хамтран аймгийн захиргааны 4 дүгээр байранд "JOB CENTER" төвийг 2025 оны 05 дугаар сарын 05-нд нээж 09 дүгээр сарын 1-нээс үйл ажиллагааг эхлүүлээд байна. Тус төв нь үүсэн байгуулагдсанаас хойш дараах үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллаж байна. Үүнд: Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөг 18 иргэнд, бүлгийн зөвлөгөөг 14 дүгээр сургуулийн 9, 11 ангийн 70 сурагчдад өгсөн. Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээнд 20 иргэнийг хамруулж, хувийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтэд нь дэмжлэг үзүүлсэн. Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй Онто гранд ХХК, Өргөө кино	100%	100%

						театр, Presting Beauty гоо сайхны дэлгүүр, Тод Өнгө ХХК зэрэг 25 аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 28 ажлын байрны захиалгын дагуу мэдээллийг "Ажил Зуучлал" нэртэй Facebook хуудсаар дамжуулан иргэдэд хүргэж ажлын байрны захиалгын дагуу 21 иргэнийг ажил олгогчийн ярилцлагад оролцуулж, 12 иргэнийг түр болон байнгын ажлын байранд дадлагажуулан ажиллуулж байна.		
3.2.2.6.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан ААНБ, ТББ, хувь хүн санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, ажлын байр бий болгосон эсэхэд хяналт тавих;		1.Хяналт шалгалтын тоо 2.Судалгаа, мэдээллийн тоо 3.Холбогдох арга хэмжээний тоо	1.Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо 30.9 мянга /2024 оны 4 улирал/ 2.Цалин хөлстэй ажиллагч 318.9 мян.хүн /2023 он/	Аймгийн хэмжээнд цалин хөлстэй ажил эрхлэгч болон албан хөдөлмөр эрхлэгчийн тоо нэмэгдсэн байна.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд нийт 2017-2025 оны хооронд 214 иргэн хамрагдсан. Үүнээс хугацаа хэтэрсэн 29 иргэнээс 13 иргэнтэй биечлэн уулзсан, үүнээс нас барсан 2 иргэн ШШГГ-т 1 иргэн, хаяг тодорхойгүй эрэн сурвалжлах шүүхийн захирамж гаргуулахаар Прокурорын байгууллагад өгсөн 13 иргэн байна. Өр төлбөр барагдуулах мэдэгдэл өгсөн 5 иргэний 4.7 сая төгрөгөөс 2 иргэн төлбөр бүрэн барагдуулан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн. Аймгийн хэмжээнд цалин хөлстэй ажил эрхлэгчдийн тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 35227 болж 5843-аар өссөн байна.	100%	100%
3.2.2.7.	Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртэй, инновац шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих,		1.Холбогдох арга хэмжээний тоо 2.Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо 3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн	2023 онд ХЭДС-аас шилдэг старт-ап залуучуудад олгох санхүүгийн дэмжлэгт 139 хүнийг хамруулж, 721.0 сая	Аймгийн хэмжээнд өндөр технологийн, бүтээмжтэй ажлын байрны тоо, аж ахуй эрхлэгч нэмэгдсэн байна.	Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох (start-up) бүсийн арга хэмжээг "Бест метод" ТББ-тай хамтран 2025 оны 09 дүгээр сарын 15-наас эхлэн 14 хоногийн хугацаатай Хөвсгөл 21, Булган 26, Орхон 64, нийт 3 аймгийн 111 залуучуудыг бүртгэж 2025 оны 10 дугаар сарын 04-06-ны хооронд 3 өдрийн сургалтыг зохион байгуулж 1 дүгээр шатны сонгон шалгаруулалтад Булган аймаг 1, Хөвсгөл аймаг 2, Орхон	70%	70%

	холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх;		хэмжээ 4.Шинээр бүртгүүлсэн патент /шинэ бүтээл, ашигтай загвар/-н тоо	төгрөг зарцуулсан.		аймаг 4, нийт 7 баг шалгарч 5 долоо хоногийн хугацаатай хурдасгуур хөтөлбөрт хамрагдаж, эцсийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж 3 багт 52.0 сая төгрөгийн 36 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй 50 хувийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгосон. Орхон аймгийн гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох (start-up) арга хэмжээг "Нэгдмэл үйлс нэг сэтгэл" ТББ-тай хамтран 2025 оны 08 дугаар сарын 25-наас 09 дүгээр сарын 09-ны хооронд бүртгэлийг зохион байгуулж, нийт 45 залуучуудыг бүртгэж 3 өдрийн сургалтад хамруулж 2 дугаар шатны шалгаруулалтад 5 баг шалгарч хурдасгуур хөтөлбөрт хамрагдаж байна. Эцсийн сонгон шалгаруулалтад 2 багт 30.0 сая төгрөгийн 36 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй 50 хувийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгосон.		
3.2.2.8.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж, арга барилыг сайжруулж шинэчлэх, томоохон ААНБ-тай гэрээ		1.Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан хүний тоо, 2.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ	2023 онд ХЭДС-аас борлуулалтын дэмжлэгт 460 хүн хамрагдаж 341,3 сая төгрөг зарцуулсан.	ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн борлуулалтын дэмжлэгийн арга хэмжээ төрөлжин нэмэгдэж, хамрагдагсдын тоо, борлуулалтын хэмжээ нэмэгдсэн	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан таниулах, борлуулалтыг дэмжих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Энэхүү ажлын хүрээнд аймгийн ETV телевиз болон байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах, мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг тогтмол зохион байгуулж байна. "Эрдэнэт түншлэл 2025" үзэсгэлэн худалдаанд нийт 6 асар түрээслэн авч, санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 14 иргэн өөрсдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ олон нийтэд	100%	100%

	байгуулж, борлуулалт хийх, хамтран ажиллах;				байна.	<p>танилцуулан борлуулсан.</p> <p>-Санхүүгийн дэмжлэг авсан хувиараа бизнес эрхлэгч 14 иргэн 3 өдрийн хугацаанд өөрсдийн бараа бүтээгдэхүүнийг иргэдэд сурталчилж, борлуулалтын үйл ажиллагаа явуулсаны үр дүнд нийт 11.4 сая төгрөгийн борлуулалт хийж, 3.7 сая төгрөгийн үнийн дүн бүхий бараа бүтээгдэхүүний захиалга авсан.</p> <p>-"Даниста худалдааны төв"-д "Эрдэнэтэд үйлдвэрлэв" борлуулалтын цэгийг байгуулж, санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 14 иргэний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг худалдаалж байна. Уг борлуулалтын цэгийн түрээсийн зардалд нийт 7.2 сая төгрөг зарцуулсан.</p> <p>-Мөн аймгийн хэмжээнд үйлдвэрлэл эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдийн бараа бүтээгдэхүүнийг нэг дор төвлөрүүлэн борлуулах, зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Эрдэнэтэд үйлдвэрлэв" нэртэй нэгдсэн борлуулалтын төвийг барьж, ашиглалтад оруулахаар ажиллаж байна.</p>		
3.2.2.9.	Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах;		Холбогдох арга хэмжээний тоо	2023 онд ХЭДС-аас хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжихэд	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн үйл ажиллагаа өргөжиж, нийгмийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөл 2025 оны эхний улиралд хуралдаж, үндэсний зөвлөлөөс баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хөтөлбөр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын 2025 оны А/50 дугаар тушаал, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2025 оны А/30 дугаар тушаалуудтай тус тус танилцаж, холбогдох мэдээллийг авсан. Мөн санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны сонгон шалгаруулах	100%	100%

				160.7 сая төгрөг зарцуулсан.	нэмэгдсэн байна.	ажлын хэсэгт зөвлөлийн гурван гишүүн ажилласан. Зөвлөлийн үйл ажиллагаа улирал бүрд хуралдаж, тайлан мэдээлэл, явцын үйл ажиллагаатай танилцаж хэвшсэн.		
3.2.2.10.	Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3, 145.4 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулах.		1.Төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ 3.Бий болсон ажлын байр, ажилд зуучлагдсан хүний тоо	2023 онд ХЭДС-нд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй ажлын байрны төлбөрөөс 6.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн.	Аймгийн хэмжээнд орлого төвлөрүүлэлт нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн нийт 172 аж ахуйн нэгж, байгууллагад судалгаа хүргүүлсэн. Судалгаанд хариу ирүүлсэн 69 байгууллагад нийт 9318 ажилтан ажиллаж байгаагаас 141 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах үүрэг хүлээсэн 26 байгууллага нийт 231 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй нь тогтоогдсон тул эдгээр байгууллагад хууль, журмын дагуу төлбөрийн нэхэмжлэл хүргүүлсэн. Үүний үр дүнд 7 аж ахуйн нэгж байгууллагаас нийт 1745436.0 мянган төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төвлөрүүлээд байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн 172 байгууллагад судалгаа хүргүүлсэн. Судалгаа ирүүлсэн 69 байгууллагын 6010 хүн ажиллаж байгаагаас ахмад настан 140 иргэн ажиллаж байна. Ажиллавал зохих 5 байгууллага 38 ахмад настан ажиллуулаагүй байна. Хөдөлмөрийн тухай хуулийг хангуулах зорилгоор мэдээллийг тус 5 байгууллагад хүргүүлсэн.	100%	100%
<b>3.2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар:</b>								
3.2.3.1.	Орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн	Орон нутгийн төсвийн	ХАБЭА-н тухай хуульд заасан	2024 оны хэрэгжилт	Хуульд заасан хэмжээнд	Орхон аймгийн хэмжээнд 2025 онд Үйлдвэрлэлийн Осол, Мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас	100%	100%

	осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төсөвлөн, зарцуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн захиргааны хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах,	хөрөнгөөр	шаардлагыг хангасан эсэх.		хүргэсэн байна.	давхардсан тоогоор 891 иргэнд 4.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр тэтгэмж төлбөр олгосон байна.ҮОМШӨ-с урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах мэргэжлийн байгууллагыг сонгох нээлттэй сонгон шалгаруулалтад Орхон аймгийн ҮЭХ-ны дэргэдэх ХАБЭА-н сургалтын төв шалгарч хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчид, тариаланчдад зориулсан сургалтад 3.5 сая төгрөг, ажил олгогч, албан журмын даатгалд хамрагдагсад болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны эрсдэл өндөр ажил олгогчдод нийгмийн даатгалын сангаас олгох ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хууль, ХАБЭА чиглэлээр хийх сургалтын зардалд 9.0 сая төгрөг зарцуулахаар гэрээ байгуулагдсан. 2025 онд Орхон аймгийн хэмжээнд ХАБЭА-н чиглэлээр 29 төрлийн арга хэмжээ, 12 гаруй сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 1000 гаруй иргэн, ажил олгогчийг хамруулсан бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэх, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй ажлын орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулсан.Эдгээр ажлуудын үр дүнд ажил олгогч, ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэг, хандлага сайжирч, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний чанар, үр нөлөө дээшилсэн.		
3.2.3.2.	Аймаг, дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Төлөвлөсөн төсөв 2.Зохион байгуулсан	2024 оны гүйцэтгэл	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Батлагдсан төлөвлөгөөний дагуу аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөлд нийт 8 ажил зохион байгуулахад 15.0 сая төгрөгийн	100%	100%

	<p>зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдыг үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах;</p>		<p>арга хэмжээний тоо</p>		<p>санхүүжилт, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021–2025 оны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд 5 зорилт, 21 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 10.0 сая төгрөг нийт 25.0 сая төгрөг баталсан. Зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор ETV телевизтэй хамтран ажиллаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр тогтмол мэдээлэл түгээж байна. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хөгжил, хиймэл оюуны хэрэглээ ба цахимжилт” уриан дор ХАБЭА-н сарын аяныг зохион байгуулж, зөвлөгөө, мэдээлэл, постер, шторк зэрэг 17 төрлийн үйл ажиллагаа, онцлох дөрвөн удаагийн сургалт, нэг спортын арга хэмжээг хэрэгжүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэг, хандлагыг нэмэгдүүлж, зөвлөлийн гишүүд болон ХАБЭА-н ажилтнуудын идэвх, хамтын ажиллагааг өргөжүүлсэн. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж–шинэчлэл” нэртэй 100 ширхэг гарын авлага боловсруулж, аж ахуйн нэгж, байгууллагуудад тараан эрх зүйн мэдээлэл, зөвлөмжийг хүргэсэн. 2025 онд “ХАБЭА-н тухай хууль тогтоомжийн хэрэгжилт” сэдвээр 75 ажил олгогчийг хамруулсан сургалт, “Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтад 30 аж ахуйн нэгжийн төлөөллийг хамруулсан. Мөн “Ажилтны</p>	
--	---	--	---------------------------	--	---	--

					<p>эрүүл мэндийн үзлэг, зохион байгуулалт” сэдвээр эрүүл мэндийн болон үйлдвэрлэлийн салбарын 30 байгууллагын ХАБЭА-н ажилтан, эрүүл ахуйч нарт зориулсан уулзалт, сургалт зохион байгуулсан. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаа–өөрчлөлт, шинэчлэл” сэдвээр сургалт зохион байгуулж, сумдын болон томоохон аж ахуйн нэгжийн 60 гаруй төлөөллийг хамруулсан. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 төрлийн нийт 570 ширхэг постер хэвлэж, 30 байгууллагад тараасан бөгөөд “Ажлын байран дахь тоосны өртөлтөөс ажилтны эрүүл мэндийг хамгаалах техникийн зохицуулалт”-ын талаар постер, мэдээллийн хуудас боловсруулан олон нийтэд хүргэсэн. Ажлын байран дахь дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийн дагуу ажил олгогчийн үүрэг, эрхийг тусгасан 90 ширхэг зурагт хуудас хэвлэн гаргаж, 30 байгууллагад тараасан. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх 170 ширхэг постерыг хэвлүүлж, байгууллагуудад түгээсэн. Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 81, 129, 187 дугаар конвенцын агуулга, ач холбогдлын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэж, ХАБЭА-н хуулийн шинэчилсэн найруулгад 9 санал боловсруулан Үндэсний хороо болон ажлын хэсэгт албан ёсоор хүргүүлсэн. Асбестын хор аюулаас урьдчилан сэргийлэх ажлын</p>	
--	--	--	--	--	--	--

						хүрээнд 8 байгууллагын 200 гаруй ажилтан, оюутнуудад мэдээлэл зөвлөмж хүргэсэн. Зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 29 мал эмч, 225 малчин өрхөд сургалт, мэдээлэл хүргэж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлсэн. Мөн ХАБЭА-н зөвлөлийн гишүүдийн оролцоо, хамтын ажиллагаа нэмэгдэж, хөдөлмөрийн аюулгүй байдлын соёлыг төлөвшүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр бодит үр дүн гарсан байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь хэрэгжсэн.		
3.2.3.3.	Хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрлэлийн томоохон осол, хурц хордлогын үед түүний хор уршгийг арилгах, хүн амыг авран хамгаалахад чиглэгдсэн шуурхай арга хэмжээг авах.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Төлөвлөсөн төсөв 2.Тухай бүр авсан арга хэмжээний тоо	2024 оны гүйцэтгэл	Тухай бүр арга хэмжээ авсан байх	Бригадын зохион байгуулалтаар ажиллаж буй иргэдэд зориулан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад анхаарах асуудал, үйлдвэрлэлийн ослын өнөөгийн байдал болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ" сэдэвт сургалтыг зохион байгуулж, нийт 50 иргэнийг хамруулсан. 2025 оны 6 дугаар сарын 12-ны өдрөөс хэрэгжиж эхлэх "Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийг танилцуулж, оролцогчдод холбогдох норм, дүрмийн хэвлэмэл номыг тараан өгсөн. Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй барилгын чиглэлийн 29 аж ахуйн нэгж, байгууллагад зориулан ном бэлтгэн хэвлүүлж, хүргүүлсэн. Мөн дээрх барилгын норм, дүрмийг салбарын хөрөнгө оруулагчид, захиалагчид, зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид болон гүйцэтгэгч иргэдэд танилцуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг зөвлөж ажиллаж, осол гэмтэл	70%	70%

						бүртгэгдэх тохиолдол бүрд комисс болон улсын байцаагч нар арга хэмжээг авч ажиллаж байна. Хурц хордлого бүртгэгдээгүй, үйлдвэрлэлийн ослоор нас баралт 2, нийт ослын тоо 23 бүртгэгдсэнийг тухай бүрд арга хэмжээг авч ажилласан		
<b>3.2.4. Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний талаар:</b>								
3.2.4.1.	Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авсан тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогчтой бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байранд дагалдуулан сургах, ажлын байраар хангах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо 2.Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн орлогын хэмжээ 3.Гадаад ажилтан ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын монгол, гадаад ажилтны тоо хэмжээний харьцааны өөрчлөлт	2024.12.15 байдлаар: Орон нутагт хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо 8.1 мянган хүн	Аймгийн хэмжээнд ажилгүйдэл буурч, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй барилгын салбарт 37, хоол үйлдвэрлэлийн салбарт 1, боловсролын салбарт 9, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 3, нийт БНХАУ, Филиппин, Чех, Иран, Фижи, Пакистаны 51 иргэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авч ажиллаж байна. Эдгээрт холбогдох хууль хяналтын байгууллагуудтай хамтран хяналт, шалгалтыг тогтмол тавьж ажиллаж байна. 2024 оны III улиралд хөдөлмөр эрхлэлтийн түвшин 43.0 байсан бол 2025 оны III улиралд 47.9 болж, 4.9 пунктээр өссөн. Ажилгүйдлийн түвшин 2024 оны III улиралд 7.4 байсан бол 2025 оны III улиралд 13.9 болж 6.5 пунктээр өссөн.	70%	70%
3.2.4.2.	Гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлж байгаа ажил олгогчид зөвлөгөө өгөх, гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн нөхцөл, Ажиллах хүчний шилжилт	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	монгол, гадаад ажилтны тоо хэмжээний харьцааны өөрчлөлт		Хуулийн хэрэгжилт сайжирсан байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын ерөнхий байцаагчийн "Гадаадаас ажилтан авч ажиллуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" 08-07/16 дугаар удирдамжийн хүрээнд 13 аж ахуйн нэгж, байгууллагад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар БНХАУ, Гана, Балба, Бангладеш, ОХУ-ын 377 иргэн Орхон аймагт хөдөлмөр эрхэлж байна. Ажлын байрны төлбөр,	100%	100%

	хөдөлгөөний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах.					хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл нь хууль тогтоомжид нийцсэн байна.		
<b>3.3. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Ахмад настны тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.</b>								
<b>3.3.1. Нийгмийн даатгалын талаар:</b>								
3.3.1.1.	Орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, залуучуудыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран зохион байгуулах;	1830877.1	Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчийн тооны өсөлтийн хувь	Улсын хэмжээнд сайн дураар даатгуулагчийн тоо 2023он 152800	Сайн дураар даатгуулагчийн тоог 10-аас багагүй хувиар нэмэгдүүлсэн байна.	Сайн дурын даатгалд нийт 4290 даатгуулагч хамрагдсан байна. Үүнд: -Энгийн сайн дурын даатгуулагч 3276 -Малчид даатгуулагч – 322 -Тэтгэмжийн даатгалын сангаас хариуцан төлж байгаа 0-3 хүртэлх настай хүүхдээ асарч байгаа эх – 398 -Улсын төсвөөс хариуцан төлж байгаа 0-3 хүртэлх настай хүүхдээ асарч байгаа эх – 324 -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг эцэг, эх даатгуулагч –152 тус тус даатгуулсан байна. 2024 онд 127 малчин сайн дурын даатгалд хамрагдаж байсан бол 2025 онд 322 малчин хамрагдаж байгаа нь өмнөх оноос 195-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Нийтдээ сайн дурын даатгалд 543 даатгуулагч шинээр хамруулж 10.5 хувиар нэмэгдүүлсэн байна. Орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 16 удаагийн шууд бичлэгээр 64778 хандалт, 208 удаагийн постероор 804791 хандалт, 44 удаагийн богино бичлэгээр 282981 хандалт авч, 20 чиглэлд 2 удаа малчдаар явуулын	100%	100%

						<p>үйлчилгээ хүргэн ажиллаж 678 өрхийн 789 малчин иргэнд мэдээлэл хүргэн, 15 удаагийн өдөрлөгөөр 243 иргэнд, 71 удаагийн сургалтаар 3431 иргэнд тус тус нийгмийн даатгалын талаарх зөвлөгөө, мэдээлэл хүргэж ажилласан.</p> <p>0-3 насны хүүхдээ асардаг нийт 456 иргэнтэй утсаар холбогдсоноос албан журмаар төлдөг 197 иргэн, сайн дурын даатгал төлдөг 40 иргэн, сайн дурын даатгал төлдөггүй 219 иргэнд, 0-18 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг 167 иргэнд, үсчин, гоо сайхны холбоонд бүртгэлтэй 71 иргэнд, ажилгүйдлийн тэтгэмж авсан 420 иргэнд тус тус утсаар зөвлөгөө мэдээлэл хүргэж ажилласан.</p>		
3.3.1.2.	Нийгмийн даатгалын үйлчилгээг аймаг, дүүргийн иргэдэд шуурхай хүргэх зорилгоор нийгмийн даатгалын цахимжуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;		Цахим хэлбэрт шилжүүлсэн тэтгэврийн хувийн хэргийн эзлэх хувь	-	Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын хувийн хэргийг 100% цахим хэлбэрт шилжүүлсэн байна.	Нийгмийн даатгалын газрын тэтгэврийн архивыг цахимжуулах ажилд орон нутгийн төсвөөс программ хангамжийн зардалд 25.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Үүний дүнд 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хойш шинээр тогтоосон тэтгэвэр авагчдын 1741 хувийн хэргийг бүрэн цахимжуулж дууссан.	70%	78.5%
3.3.1.3.	Даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд ажил олгогч хуулиар хүлээсэн эрх, үүргээ биелүүлж, нийгмийн		Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын тоо	Улсын хэмжээнд өртэй төсөвт байгууллагын тоо -848	0	2025 оны эхэнд төсөвт байгууллагын шимтгэлийн өр, авлага 14 байгууллагын 132914.4 мянган төгрөг байсныг бүрэн барагдуулсан.	70%	70%
						2025 оны жилийн эцсийн байдлаар төсөвт байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлага барагдуулахад анхааран ажиллаж		

	даатгалын шимтгэлийн өр үүсгэхгүй байх, өр үүссэн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг шуурхай барагдуулахад Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;					байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төв 859817.6 мянган төгрөгийн НДШ-ийн өртэй гарах тооцоололтой байна. Энэ нь Эрүүл мэндийн яамнаас баталсан төсөвтэй хамааралтай өр үүссэн байна.		
3.3.1.4.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчлүүлэх нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах;		Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо	Улсын хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо 102446	Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоог 25 хувиар бууруулсан байна. (МУ-ын хэмжээнд нийт зорилт)	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгахдаа иргэнийг өөрийн биеэр ирүүлэхгүйгээр шийдвэрлэсэн байдал 90 хувьтай байна. Хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах нөхөн сэргээх чиглэлээр БОЭТ-ийн физик эмчилгээ нөхөн сэргээх тасагтай хамтран ажиллаж байгаа бөгөөд төрөлжсөн мэргэжлийн эмч нарын ЭММЗ-д ажиллах хугацааны гэрээнд хөдөлмөрийн чадвараа алдсан иргэн /даатгуулагч/-ний эдгэрэлт нөхөн сэргээлтийн талаарх заалт нэмж тусган үр дүнг тооцон ажиллаж байна. 2023 онд 3390, 2024 онд 3190, 2025 онд 3140 иргэн хөдөлмөрийн чадвар алдалтын акт тогтоолгосон байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн тоог 2025 онд 2.5 хувиар бууруулах төлөвлөгөөнд тусгагдсанаас тайлант хугацаанд 5.8 хувиар бууруулсан.	70%	70%

3.3.1.5.	Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай холбогдуулан орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаа хийхэд хамтран ажиллах		Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаагаар болсон байна.	Орхон аймгийн хэмжээнд 29233 иргэн тэтгэврийн даатгалын санд 150.4 тэрбум төгрөгийн шимтгэл төлснийг Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газарт төвлөрүүлэн ажилласан. Тэтгэврийн даатгалын санд төлсөн шимтгэлийн 2 хүртэлх хувийг бодит мөнгөн хуримтлал болгох ажлыг Нийгмийн даатгалын Ерөнхий газар улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж байна.	100%	100%
<b>3.3.2. Нийгмийн халамжийн талаар:</b>								
3.3.2.1.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд согтууруулах, мансууруулах бодис хэрэглэдэг өрхийг хамруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, үүнээс хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхөөс шинээр хөдөлмөр эрхэлсэн иргэний тоо	-	Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийг орлогын эх үүсвэртэй болгох, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд хамруулсан байна.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд орон нутгийн төсвөөс 132.5 сая төгрөг батлагдсан ба үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуй нэгж, байгууллага, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулсан. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэнд үзүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэх 58.5 сая төгрөг (Хамтдаа тэмүүлэх гэрэлт ирээдүй ТББ), Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээг үзүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэх 40.5 сая төгрөг (Улаан загалмайн хороо), хөгжлийн бэрхшээлтэй иргэнд болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэх 33.5 сая төгрөг (Аминчхан яриа ТББ) тус тус сонгон шалгарч гэрээ байгуулан	100%	100%

						<p>үйлчилгээг үзүүлсэн.</p> <p>Улаан загалмайн хороо өрх толгойлсон эх эцэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 33 өрхийг сонгон 6 сарын хугацаанд өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, сургалт, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, хэрэгцээ шаардлагын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагад холбон зуучлах зэргээр үйлчилгээг үзүүлсний зэрэгцээ өрхийн үйлдвэрлэл эрхлэх боломжтой 11 өрхийг 5 бүлэг болгон төсөл хэрэгжүүлж, өрх тус бүрд 1.8 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, түүхий эд материал олгосон.</p> <p>Аминчхан яриа ТББ гэрээлэн гүйцэтгэж, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 60 иргэний асран хамгаалагчдад асаргаа сувилгааг хэрхэн зөв зохистой хийх, сэтгэлзүйн бүлгийн болон ганцаарчилсан зөвлөгөө сургалт арга хэмжээг 6 сарын хугацаанд зохион байгуулсан.</p> <p>Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа болон Нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай зорилтод өрхийн 54 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 74 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад 80 иргэнийг хамруулж зөвлөгөө мэдээлэл өгсөн. Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 10 иргэн, мэргэжил олгох сургалтад 19 иргэн хамрагдсан байна.</p>		
3.3.2.2.	Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх,	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Дэмжих бүлгийн тоо, 2.Архинаас гарсан	-	Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг	Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэнд үзүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг "Хамтдаа тэмүүлэх гэрэлт ирээдүй"	100%	100%

	донтолтоос ангижруулах арга хэмжээг орон нутагтаа холбогдох талуудыг оролцуулан зохион байгуулах, архинаас гаргах дэмжих бүлгүүдтэй хамтран ажиллах;		иргэний тоо, үүнээс хөдөлмөр эрхэлж тогтмол ажлын байртай болсон хүний тоо		нийгэмшүүлэх, донтолтоос ангижруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	НҮТББ-тай байгуулсан хамтран ажиллах гэрээг сунган, 2025 оны 01 дүгээр сарын 1-нээс 02 дугаар сарын 15-ны хооронд гэр оронгүй тэнэмэл иргэдийг хооллох, хоноглох үйлчилгээнд хамруулж 27.6 сая төгрөг зарцуулсан. Уг үйлчилгээ хүйтний улиралд хэрэгждэг тул 11 дүгээр сарын 15-наас үргэлжлэн 30 иргэнийг үйлчилгээнд хамруулж, 58.5 сая төгрөгийг нийгмийн халамжийн сангаас зарцуулан ажилласан. Орон нутгийн төсвөөс нэмэлт 20.0 сая төгрөг батлагдсаныг 1 ээлжийн өвлийн дулаан хувцас авахад 11.2 сая төгрөг, ариун цэвэр, ахуйн үйлчилгээнд 2.1 сая төгрөг, эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд 1.8 сая төгрөг, нийгэмшүүлэх арга хэмжээнд буюу нөлөөллийн шатлалт сургалт үйл ажиллагаанд лекц, бүлгийн сэтгэл заслын сургалт, 10 иргэнд сэтгэлзүйн ганцаарчилсан 4 удаагийн давтамжтай зөвлөгөө үйлчилгээнд 2.2 сая төгрөг, тэмдэглэлт баярын арга хэмжээнд 1.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан. Үйлчилгээнд хамрагдсан иргэдээс 4 иргэн мод үржүүлгийн газар, 2 иргэн барилга засварын түр ажил эрхэлж байна.		
3.3.2.3.	Нийгмийн ажилтнуудын бусад салбарын ажилтнуудтай хамтран ажиллах ажлын уялдаа холбоог сайжруулах, чадавхжуулах сургалтад	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, 2.Сургалтын тоо	-	Нийгмийн ажилтнуудын мэдлэг ур чадвар сайжирсан байна.	2025 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна. Үүнд: - Төрийн албаны зөвлөлийн семинар 7:4:10 сургалтад албан хаагчдыг тогтмол хамруулан, ангилал зэрэглэл харгалзахгүйгээр мэдлэг, мэдээлэл олгож хэвшсэн. - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг	100%	100%

	<p>ТОГТМОЛ хамруулах</p>					<p>хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох А3 гэрчилгээний хугацаа дууссан болон шинэ авахаар 10 албан хаагч сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 1 албан хаагч, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 3 албан хаагч, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч тус тус элсэн суралцаж байна.</li> <li>- Шинээр батлагдсан "Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS7068:2025 стандарт"-ыг танилцуулах сургалтын нийт албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан.</li> <li>- Дохионы хэлний ур чадварыг хөгжүүлэх, сонсголгүй иргэдтэй дохионы хэлээр харилцах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор "Брайль бичгийг түгээн дэлгэрүүлэх сургагч багш бэлтгэх" 2 кредит цагийн сургалтад 3 албан хаагчийн хамруулан суралцуулснаар дохио, зангаа, биеийн хэлэмж, нүүрний хувирлыг ашиглан өөрийгөө илэрхийлэх, сонсголын бэрхшээлтэй хүүхэд, иргэдтэй өдөр тутмын харилцааны сэдвүүдийн хүрээнд харилцаж, тэдний өвөрмөц онцлог, ахуй соёлын хэрэгцээг ойлгох мэдлэг, чадварыг эзэмшсэн.</li> </ul> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр) болон хэрэгжүүлж ажиллах удирдамжийг танилцуулах сургалтыг 36 мэргэжилтэнд зохион байгуулсан.</p>	
--	------------------------------	--	--	--	--	---	--

						Ажилтан, албан хаагчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор нийтдээ 6 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Орон нутагт зохион байгуулагдсан 8 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 78 мэргэжилтэн оролцож сургалтаас олсон мэдлэгээ чадвар, дадал болгон ажиллаж байна. Төрөл бүрийн чиглэлээр 30 гаруй удаагийн сургалт, арга хэмжээнд давхардсан тоогоор 200 гаруй нийгмийн ажилтан хамрагдсан.		
<b>3.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар:</b>								
3.3.3.1.	Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Сургалт	-	30-аас доошгүй	Гэрээлэн ажиллаж буй 7 ТББ, хүүхэд хөгжлийн төвүүдтэй хамтран 20 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 550 хүн, ЭМГ, БТСГ, БГ зэрэг төрийн байгууллагуудтай хамтран тэгш эрхийн сургалт, асран хамгаалагчдын сургалт, нөхөн үржихүйн боловсрол олгох сургалт, дохионы хэлний сургалт 2 шатны сургалт, конвенцын үндсэн ойлголт зэрэг зэрэг нийт 10 удаагийн сургалтуудыг явуулж 250 хүн, нийт 30 удаагийн сургалт, өдөрлөг, нөлөөллийн арга хэмжээнд 800 гаруй хүнийг хамруулсан.	100%	100%
3.3.3.2.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	20	"Хүний эрх ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоо" сэдэвт сургалтыг Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны Орхон аймаг дахь салбар зөвлөл болон Хүний эрхийн үндэсний комиссын орон нутаг хариуцсан төлөөлөгч, Хангайн бүсийн Улс төрийн академийн багштай хамтран зохион байгуулж нийт 30 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдсан. ТББ-уудтай хамтран 8 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион	100%	100%

						байгуулж 150 хүн, төрийн байгууллагуудтай хамтран тэгш эрхийн сургалт, асран хамгаалагчдын сургалт, нөхөн үржихүйн боловсрол олгох сургалт, дохионы хэлний сургалт 2 шатны сургалт, конвенцын үндсэн ойлголт зэрэг зэрэг нийт 10 удаагийн сургалтуудыг явуулж 250 хүн хамруулсан.		
3.3.3.3.	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багш бэлтгэн, орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Зохион байгуулсан сургалтын тоо	-	3	Аймгийн хэмжээнд нөхөн үржихүйн насны (15–49 насны) 676 эмэгтэйчүүд байна. БОЭТ, ӨЭМТ-үүд зорилтод бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд чиглэсэн нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна. Зорилтод бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгааг гаргаж нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг нийтдээ 4 удаа хөгжлийн бэрхшээлтэй 144 иргэдэд зохион байгуулсан. БЗДХ, HCV, HBV шинжилгээ болон үзлэгт 508, жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэлд 127 хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамрагдсан байна.	100%	100%
3.3.3.4.	Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх дэмжих төвийг байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Дэмжих төв	-	1	Нийгмийн халамжийн сангаас 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох тэтгэмж нийт 504 хүүхдэд 1.7 тэрбум төгрөгийн тэтгэмжийг олгосон. Засгийн газрын 247 дугаар тогтоолын дагуу хүнд хэлбэрийн болон хавсарсан оноштой хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асран хамгаалж байгаа асран хамгаалагч нарт олгох асаргааны тэтгэмжийн хэмжээ 30 хувиар нэмэгдсэнтэй холбогдуулан 189 хүүхдийн асран хамгаалагч нарт 1-5 сарын зөрүү нэмэгдэл болох 134.6 сая	100%	100%

						<p>төгрөгийг нийгмийн халамжийн сангаас нөхөн олгосон.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуусыг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Гэрэл, Найдвар, Сорхугтани, Пондолдой зэрэг нийт 4 төвтэй 233.2 сая төгрөгийн гэрээ байгуулан, нийгэмшүүлэх, өдөр өнжүүлэх, сэргээн засах үйлчилгээнүүдийг хүргэж байна. Эдгээр төвүүдэд нийт 15 багш, ажилтнууд ажиллаж нийтдээ 80 гаруй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа шаардлагатай хүүхэд, залууст төрийн үйлчилгээг гэрээгээр үзүүлж байна. 2025 онд нийт 35 төрлийн арга хэмжээнд хүүхэд, залуус, асран хамгаалагчид, албан хаагчид зэрэг 600 гаруй хүнийг оролцуулан зохион байгуулсан.</p>		
3.3.3.5.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	2	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаа тогтмолжин орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг хууль, дүрэм зааврын хүрээнд хэрэгжүүлэн ажилласан. Тус комисс нь 2025 онд 20 удаа хуралдаж, нийт 411 хүүхдийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулан үйлчилгээ үзүүлэн ажилласан. Үүнээс 63 шинээр, хөдөлмөрийн чадвараа алдалт 31, онош болон заалтгүй болж цуцлагдсан 34, байнгын асаргааг сунгасан 132, хүнд онош тодруулахаар 49, бусад онош тодруулах, хяналтад явах зэргээр буцаагдсан 102 хүүхдэд тус тус шийдвэр гарган ажилласан.</p> <p>Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн</p>	100%	100%

						<p>хуралд оролцохоор ирсэн иргэд болон тэдний асран хамгаалагч нарт Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох тогтоол, журам, шийдвэрүүд болон холбогдох мэдээлэл өгсөн. Түүнчлэн иргэдээс санал хүсэлтийг бичгээр авч холбогдох байгууллагуудад уламжилж, шийдвэрлүүлэн ажилласан.</p> <p>Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс нь 48 удаагийн хурлыг зохион байгуулж, шинээр болон давтан магадлуулсан 2416 иргэнд мэдээллийг хүргэн ажилласан. Түүнчлэн сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээг саадгүй хүргэх зорилгоор төрийн албан хаагчдын дунд дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн ахисан шатны 2 өдрийн сургалтыг зохион байгуулж, 15 байгууллагын 25 ажилтан, албан хаагч хамрагдаж, мэдлэг чадвараа ахиулж, чадавхажсан</p>		
3.3.3.6.	Орон нутгийн гамшгаас хамгаалах, онцгой байдлын үед авах арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг тусган боловсруулж, хоргодох байрны хүртээмжийг нэмэгдүүлэх	Орон нутгийн төстийн хөрөнгөөр	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-	100	<p>Гамшиг осол, онцгой нөхцөл байдлын үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сургалт зохион байгуулах төлөвлөгөөний хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2025 оны А/406 дугаар тушаалаар батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах заавар", Гамшгаас хамгаалах сургалтын газрын даргын баталсан 2025 оны 04/2963 үүрэг чиглэлийг үндэслэсэн нийт 3 удаагийн сургалтыг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй 15 хүн хамрагдсан. Дохионы хэлний гэсэн сургалтад ОБГ-аас албан хаагчид хамрагдсан. Орхон аймгийн хэмжээнд түр хоргодох байраар ашиглах боломжтой нийт 21</p>	100%	100%

						байгууламжийг 12930 орны хүчин чадалтай аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгасан. Мөн түр цугларах 20 цэгийг аймгийн Засаг даргын 2022 оны А/174 дүгээр захирамжаар баталгаажуулан, Дэлхийн зөн Олон улсын байгууллагын санхүүжилтээр тэмдэгжүүлсэн.		
3.3.3.7.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн чадавхжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	5	-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг, сургуульд ирж, очих унааны зардалд 71 иргэнд 14.2 сая төгрөг нийгмийн халамжийн сангаас олгосон. -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны Орхон салбартай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжилд эцэг, эхийн оролцоо” сэдэвт сургалтыг 2 удаа зохион байгуулж орон нутгийн төсвөөс 2.0 сая төгрөг зарцуулсан. -Харилцааны гайхамшиг ТББ-тай хамтран эцэг, эх асран хамгаалагчдад сэтгэл зүйн бүлгийн 2 өдрийн сургалтыг зохион байгуулж 20 эцэг эх хамрагдсан. -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг 4 ТББ-уудтай хамтран эцэг эхчүүдэд тайлант өдөрлөгийн нийтдээ 8 удаа зохион байгуулсан. -“Эрхэм нандин сувд” ТББ-тай хамтран аутизм, тархины саа саажилт, уналт таталт, эпилепси, тархины усжилт зэрэг оноштой 34 хүүхдүүдийг ЭХЭМҮТ-д нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулж орон нутгийн төсвөөс 3.0 сая төгрөг зарцуулсан.	100%	100%
3.3.3.8.	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлыг Төрийн	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Гэрээ байгуулан хамтран ажилласан ТББ-ын тоо	-	3	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн нийт 172 аж ахуйн нэгж, байгууллагад судалгаа хүргүүлсэн болно. Судалгаанд хариу ирүүлсэн 69 байгууллагад нийт 9318	100%	100%

	бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах;					ажилтан ажиллаж байгаагаас 141 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах үүрэг хүлээсэн 26 байгууллага нийт 231 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй нь тогтоогдсон тул эдгээр байгууллагад хуульд заасан төлбөрийн нэхэмжлэл хүргүүлсэн. Үүний үр дүнд 7 аж ахуйн нэгж байгууллагаас нийт 1.7 тэрбум төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төвлөрүүлсэн. Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хүмүүн бие даах төвтэй хамтран ААНБ-уудад ажлын байрны тохируулгад орчин бүрдүүлэх чиглэлээр нөлөөллийн ажлыг зохион байгуулж 10 ААНБ хамруулан үнэлгээ, нөлөөллийн ажил зохион байгуулж ОНТ-өөс 5.8 сая төгрөг зарцуулсан. ХБХЭЭХ-той хамтран "Хүртээмжтэй орон нутаг" төслийн хүрээнд 6 аж ахуйн нэгж, байгууллагад үнэлгээ хийсэн. ХХҮГ, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн цогц институт" ТББ-тай хамтран "Тохируулгат ажлын байр" сургалтыг хамтран зохион байгуулж 50 гаруй аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулсан		
3.3.3.9.	Орон нутгийн цахим хуудас, телевиз, нийгмийн мэдээллийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Хүртээмжтэй хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудасны тоо	-	5	Аймгийн хэмжээнд нийт 10 гаруй хэвлэл мэдээллийн байгууллага тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс телевиз 4, сайт 8 байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын вэб сайт, пэйж хуудас болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээний хүрээнд хөгжлийн бэрхшээлийн асуудлаар нийгэмд чиглэсэн мэдээ, мэдээлэл бэлтгэх, хуулийн хэрэгжилтийг сурталчилсан контент бэлтгэн хамтран ажиллахаар	70%	70%

						тусгагдсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны пэйж хуудас болон бусад хэвлэл мэдээллийн байгууллагууд, тэдгээрийн сошиал хуудсууд нь зарим мэдээ мэдээллийг бэлтгэн хүргэхдээ хадмал орчуулгатайгаар буюу титр тавьж хэвшсэн байна. Тухайлбал “Эрдэнэт Инфо” сайтын “Мийт ап” видео контент, Geregtv.mn, YGD.mn, Update.mn зэрэг сайтууд, Номин, ETV, Тусгал телевизүүд өөрийн нэрийн контентууд болон аймаг орон нутгаас хийж хэрэгжүүлж буй ажил, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалт, шийдвэрүүдийн талаар мэдээлэл хүргэхдээ титр тавьж байна. Сургалт, хэлэлцүүлэгт сонсголын бэрхшээлтэй иргэд оролцох тохиолдолд дохионы хэлний орчуулагч ажиллуулахад анхаарч ажиллаж байна.		
3.3.3.10	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл, олон талт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шаардлагатай зардлыг шийдвэрлэх, салбар, байгууллагуудын оролцоо, хамтын	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	90	Орхон аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаа тогтмолжин орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг хууль, дүрэм зааврын хүрээнд хэрэгжүүлэн ажилласан. Тус комисс нь 2025 онд 20 удаа хуралдаж нийт 411 хүүхдийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулан үйлчилгээ үзүүлэн ажилласан байна. Үүнээс 63 шинээр, ХЧА 31, онош болон заалтгүй болж цуцлагдсан 34, байнгын асаргаг сунгасан 132, хүнд онош тодруулахаар 49, бусад онош тодруулах, хяналтад явах зэргээр буцаагдсан 102 хүүхдэд тус тус шийдвэр гарган ажилласан.Тус	100%	100%

	ажиллагааг сайжруулах;					<p>комисс нь салбар, байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр 3 удаа сургалт мэдээлэл өгч ажилласнаас гадна Хөвсгөл аймагт хойд бүсийн сургалтад хамрагдсан.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийг журамд заасны дагуу улирал бүр 1, нийтдээ 4 удаа хуралдуулсан. Хурлаар 2025 онд хийх ажлын төлөвлөгөөг баталж, шинээр батлагдсан дүрэм, журмуудыг танилцуулж, гэрээ байгуулж ажилласан ТББ-ууд, төрийн байгууллагуудын 2025 оны тайланг хэлэлцсэн. Салбар зөвлөл нийтдээ 4 зорилт бүхий 21 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 21 ажлынхаа хүрээнд 32 үйл арга хэмжээг хэрэгжүүлж төлөвлөгөөний биелэлт 100% гүйцэтгэсэн.</p>		
3.3.3.11	Төрийн үйлчилгээний байгууллагын барилгын гадна байгууламжийн дотор талын хүртээмжийг сайжруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Хүртээмжтэй болгосон байгууллагын тоо Үүнээс: эхний ээлжинд НДГ, ХХҮГ, ХГБХХГ, Нэг цэгийн үйлчилгээний төв	-	3	<p>-Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй замын ажилд тактел зам, тэмдэг тэмдэглэгээ хийж байгаа эсэхэд хяналт хийгдэж, хүлээн авах комисст хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөлөл ажиллаж байна.</p> <p>-Гэрлэн дохионы 2 уулзварт дуут дохио ажиллаж байна.</p> <p>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажилладаг төрийн байгууллагууд болон эрүүл мэндийн салбарын байгууллагуудын албан хаагчдыг хамруулсан дохионы хэлний 3 удаагийн сургалт хийж 57 хүнийг хамруулсан.</p> <p>-Байгууллагуудад Монгол улсын MNS 2055:2009 "Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай,</p>	100%	100%

					<p>орчин. Үндсэн шаардлага"-ыг хангаж ажиллах зөвлөмжийг хүргүүлж үүрэг чиглэл өгсөн.</p> <p>-Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар стандартын шаардлага хангасан 15 ширхэг 40-45 хүний багтаамжтай, хөгжлийн бэрхшээлтэй иргэн саадгүй зорчих боломжийг бүрдүүлсэн дунд оврын автобусыг худалдан авч иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээг хүргэж байна.Шат болон тэргэнцэр орох зориулалтын буулгадаг хавтантай</p> <p>-2023 онд төрийн бүх шатны 92 объектын 120 байгууллагыг хамруулан Монгол улсын MNS 2055:2009 "Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага", MNS: 6808:2019 "Явган хүний зам талбайн төлөвлөлт, техникийн шаардлага" зэрэг стандартыг танилцуулж байгууллагад хэрэгжсэн байх 5 үндсэн үзүүлэлт болох автомашины зогсоолын тэмдэг, тэмдэглэгээ, налуу зам, гадна, дотор хаалганы өргөн, босгоны өндөр, хаалга хоорондын зай, угтах үйлчилгээний лангуу, мэдээллийн самбар, чиглүүлэгч, тэмдэг тэмдэглэгээ, ариун цэврийн өрөө тоноглол, хурал олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах заалны стандарт, зохион байгуулалт, дохиоллын систем зэргийн стандартыг газар дээр нь хэмжилт хийн танилцуулж арга зүйн зөвлөгөө өгсөн. Төрийн болон төрийн өмчит байгууллагуудын удирдлагууд нийт 70 хүнд хэвлэмэл стандарт түгээж, сурталчлах нөлөөллийн ажил хийсэн. Үзлэгт</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>хамрагдсан бүх байгууллагад албан бичгээр зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжүүлж ажиллахыг үүрэг чиглэл болгосон.</p> <p>-2024 онд нийтийн зориулалттай 198 /738 орц/ орон сууцны барилга байгууламжид хүртээмжийн үнэлгээ хийж, дүгнэлт гарган холбогдох газруудад мэдээллийг хүргүүлсэн.</p> <p>-2025 онд Хараагүйчүүдийн холбооны Орхон аймаг дах салбартай хамтран явган хүний зам, гарц, авто замын гэрлэн дохионд хүртээмжид судалгаа, үнэлгээ хийгдсэн. Аймгийн ХХҮГ, НДГ, Залуучуудын ордон, БОЭТ, ЭМГ, БГ/Нэг цэгийн үйлчилгээний төв/ зэрэг байгууллагуудын хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд орон нутгийн төсвийн 250.0 сая хөрөнгө оруулалтаар "RHETUS" компанитай хамтран шатаар зөөвөрлөгчөөр байгууллагуудыг хангасан.</p>			
3.3.3.12	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв байгуулах.	-	Хөгжлийн төвийн тоо	-	1	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залууст, иргэдэд чиглэсэн сэргээн засалтын болон хөгжүүлэх үйлчилгээг 7 ТББ-д гэрээлэн гүйцэтгүүлж жилдээ орон нутгийн төсвөөс 400.0 орчим сая төгрөгийг зарцуулж байна. Гэсэн хэдий ч тухайн байгууллагуудын боловсон хүчний нөөц, чадавх, мэргэжлийн арга зүйн дутмаг байдал, хяналтын тогтолцоо байдаггүй зэргээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээг хүртээмжтэй үзүүлэхэд учир дутагдалтай байгааг үндэслэн Орхон аймагт хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдүүдэд тусгайлан зориулсан хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, сэтгэл засал, сэргээн засах, нийгмийн хөгжлийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх</p>	70%	50%

						хөгжлийн цогц төв байгуулах зайлшгүй шаардлага үүсч 2024 онд 8.5 тэрбум төгрөгийн өртөг бүхий "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв"-ийн зураг, төсвийг "ЭМ ЭМ ЭЛ" ХХК-иар гүйцэтгүүлж Барилгын хөгжлийн төвд 2024 оны 07 дүгээр сарын 26-ны өдрийн 1272/2024 дугаар магадлалын дүгнэлт гаргуулсан. Улсын төсөвт тусгуулахаар 2025 оны төсөвт санал өгсөн хэдий ч хасагдсан тул дахин 2026 оны улсын төсөвт тусгуулахаар дахин саналыг хүргүүлсэн ч хасагдсан. Барилгыг барих газрыг Орхон аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 36 дугаар захирамжаар шийдвэрлэсэн.		
<b>3.3.4. Жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар:</b>								
3.3.4.1.	Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл,	Орон нутгийн төстийн хөрөнгөөр	1.Сургалт, мэдээллийн тоо 2.Сурталчилгаа нөлөөллийн ажлын тоо	-	5-аас доошгүй удаа зохион байгуулсан байна.	2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг даргын захирамжаар батлуулсан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран гэр бүлийн боловсрол олгох сургалт, өглөөний уулзалт, жендэрт суурилсан хүчирхийллийн 16 хоногийн аян, технологид суурилсан хүчирхийллийн эсрэг цахим хичээл, сурталчилгаа зэрэг нөлөөллийн 10 төрлийн арга хэмжээг зохион байгуулж, орон нутгийн төсвөөс 20.0 сая төгрөгийг зарцуулан давхардсан тоогоор 16270 иргэнийг хамруулсан. Тухайлбал: -Өсвөр үе хүүхэд багачуудад хөгжил хамгааллын өдрийн үйлчилгээ, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр 2 ТББ-тай гэрээ хийж, 6.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. -Иргэд олон нийтэд жендерийн талаарх	100%	100%

	хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрыг түшиглэн зохион байгуулна					<p>ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр "Жендэрийн ерөнхий ойлголт", "Жендэрт суурилсан хүчирхийлэл"-ийн тухай сургалтад 5 байгууллагын 152 албан хаагч хамрагдаж, ажлын байран дахь жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт сургалтад 12 албан хаагч онлайнаар хамрагдсан. Жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн боловсрол, эрчүүдийн эрүүл мэнд сэдвийн хүрээнд бүлгийн ярилцлагыг үе шаттай зохион байгуулж, давхардсан тоогоор 425 иргэнийг хамруулсан.</p> <p>-Жендэрийн үндэсний хороотой хамтран менторшип хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төрийн байгууллагын удирдлагуудад жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт сургалтад 80 хүн хамрагдсан.</p> <p>-Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг 16 хоногийн аяны хүрээнд сургалт, цахим хичээл, контент, жендэрийн ойлголтыг шалгах тест зэрэг арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 3983 гаруй иргэдийг хамруулж, 10,0 сая төгрөг зарцуулсан.</p> <p>-Жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр "Бүх хайраа гэр бүлдээ аян", гэр бүлийн боловсрол олгох сургалт, сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ, гэр бүлийн гишүүдийн бүлгийн ярилцлага зэрэг олон талт арга хэмжээг зохион байгуулан давхардсан тоогоор 11000 иргэнийг хамруулснаар гэр бүлийн үнэ цэнэ, хариуцлагын талаарх мэдээлэл нэмэгдсэн үр дүнтэй байна.</p>		
<b>3.3.5. Ахмад настны талаар:</b>								
3.3.5.1.	Ахмад настны тухай хуулийг	Орон нутгийн	Сургалт сурталчилгаа,	-	Иргэдийн ахмад настны	Ахмад настны тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор	100%	100%

	хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон нийтэд нөлөөллийн ажил зохион байгуулах;	төсвийн хөрөнгөөр	нөлөөллийн ажил 2		тухай хуулийн мэдлэг, мэдээлэл сайжирсан байна.	Засаг даргын шуурхай хуралдаанаар хэлтэс, агентлагийн дарга удирдлагуудад хуулийн нэмэлт өөрчлөлтийг танилцуулсан. Түүнчлэн хуулийг дагалдан гарсан журам, тушаалууд шинэчлэгдсэнтэй холбоотойгоор холбогдох мэргэжилтнүүдэд сургалт, цахим системд гарч буй нийтлэг алдаануудын талаарх арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан. Мөн 26 багийн ахмадын холбооны дарга, холбогдох хүмүүст Ахмад настны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт болон ахмадын шинэ төрлийн үйлчилгээг хэрэгжүүлэхтэй холбоотой уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулан ажилласан.		
3.3.5.2.	Ахмадын сан байгуулан ажиллуулах, тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ААНБ-тай хамтран ажиллах, хяналт тавих;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1. Ахмадын сан байгуулсан байгууллагын тоо, 2. Тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөө хэрэгжүүлсэн байгууллагын тоо	Ахмадын сан байгуулсан ААНБ-ын тоо, тэтгэвэр бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлсэн ААНБ-ын тоо	ААНБ-ын 50-аас дээш хувь ахмадын сан байгуулсан байна.	Орхон аймгийн хэмжээнд нийт 1916 ААНБ үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 447 ААНБ нь ахмад настантай, 83 ААНБ мэдээ тайлан ирүүлдгээс 38 нь тогтмолжсон үйл ажиллагаатай. 73 байгууллага нь ахмадын сантай байна. "Ахмадын сан" байгуулах бөгөөд "Ахмадын сан" байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална гэж 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. Уг нэмэлт өөрчлөлтийн хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөр "Ахмадын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, нийт байгууллагууд өөрийн байгууллагын 2026 оны төсвийн 3 хүртэлх хувийг байгууллагын ахмадуудад зарцуулах талаар тооцоолж ажиллах" гэсэн үүрэг даалгавар өгсөн бөгөөд үүрэг даалгаврын хэрэгжилтийг төсвийн 38 байгууллагаас 22 байгууллага	70%	32.6%

						ирүүлснээс 20 байгууллага төсвийн 1 хувийг байгууллагын ахмадуудад зарцуулахаар тооцоолон ажиллаж байгаа бол 3 хувиар тооцоолсон 1 байгууллага /НДГ/ байна.		
3.3.5.3.	Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний болон Ахмадын ордон, өргөө байгуулах, тэдний үйл ажиллагаанд зарцуулах төсвийн саналыг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, Ахмадын өргөөг ахмад настан бүрт нээлттэй байх талаар анхаарч ажиллах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Баталсан төсвийн хэмжээ /сая.төг/ 2.Үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо	Нийт ахмадын 60%	-20-оос доошгүй хувьд хүрсэн байна. -Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, -Үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо нэмэгдсэн байна.	Орхон аймгийн хэмжээнд ахмад настанд зориулан ашиглагдаж байгаа 2 ордон, 12 өрөө, 3 байр /хороололд/, 2 үйлчилгээний бус зориулалттай байр байна. 2026 онд улсын төсөвт Баян-Өндөр сумын "Өөдрөг" ахмадын хорооны байрыг барихаар 2.0 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан. Ахмадын ордны өрөө тасалгааны зохион байгуулалтыг шинэчлэн 3 өрөөний урсгал засварыг батлагдсан төсвөөс 2.5 сая төгрөгөөр засварласан. Аймгийн Ахмадын хороо нь орон тооны 10 ажилтантай, жилийн 114.6 сая төгрөгийн цалингийн сантайгаар ажиллаж Баян-Өндөр сумын 26 багийн ахмадын зөвлөлийн дарга нарт сар бүр 170.0 мянган төгрөг жилд 53.0 сая төгрөг олгож байгаа бол Баян-Өндөр сум 21.6 сая төгрөгийн, Жаргалант сум 15.5 сая төгрөгийн цалингийн сантай ажиллаж байна. Аймгийн Ахмадын хороо нь сар бүрийн календарийн өдрөөр ахмадуудад нээлттэй үйлчилгээг хуваарийн дагуу өглөө 08.00 цагаас орой 18.00 цагийн хооронд хүргэж нийтдээ давхардсан тоогоор 20.0 мянга гаруй ахмадад хүрч ажилласан байна.	100%	100%
3.3.5.4.	Ахмадын идэвхтэй насжилтыг дэмжих төвийг байгуулж, ахмад настны эрэлт,	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Үйлчилгээнд хамрагдсан тоо	-	Ахмадыг үйлчилгээнд бүрэн хамруулсан байна.	Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээг 2 багцад, ахмад настныг өдрөөр болон гэрээр асрах /явуулын/ үйлчилгээ 1 багцад, нийт 3 багцад тендер зарласан ба Баян-Өндөр, Жаргалант суманд идэвхтэй насжилтыг	100%	100%

	хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжих;					<p>дэмжих төвийн үйлчилгээнд 2 оролцогч оролцож аймгийн Ахмадын хороотой гэрээ байгуулсан. Баян-Өндөр сумын Ахмадын хороо нь 2025 оны 06 сараас үйл ажиллагааг хэрэгжүүлж, 26 багийн 750 ахмадад 50.0 сая төгрөг, Жаргалант суманд Улаан толгой ахмадын хороо нь 3 багийн 150 ахмадад 20.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр үйлчилгээг хүргэсэн. Дээрх 2 байгууллага нь 7 хоног бүр ажлаа төлөвлөн шинэ ахмадууд хүлээн авч лавлагаа, мэдээллийн үйлчилгээ, хууль, эрх зүйн зөвлөгөө, сайн дурын үйлчилгээ, ганцаарчилсан болон бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөө, ахмад настны хөгжлийг дэмжих үйлчилгээ, ахмад настны зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээг үзүүлж, сэтгэл ханамжийн судалгаа авч ажилласан.</p> <p>Мөн аймгийн Ахмадын хороо өдөр бүр 40-60 ахмад, сард дунджаар 890 гаруй ахмад настанд 6 төрлийн өрөө тасалгаагаар төрөл бүрийн үйлчилгээг үзүүлдэг ба "Идэвхтэй насжилтыг дэмжих" үйлчилгээний сонгон шалгаруулалтад тэнцэж Баян-Өндөр сумын 26 багаас 587 Жаргалант сумын 200 ахмад нийт 787 ахмад настанд ахмад настны тухай хулийн 7-р зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.1.5, 7.1.9, 7.1.10, 7.1.11 дүгээр заалтуудын дагуу үйлчилгээ үзүүлсэн болно.</p>		
3.3.5.5.	Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэл зүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Цогц үнэлгээнд хамрагдсан ахмад настны тоо		Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар,	Аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/554 "Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийн бүрэлдэхүүнийг байгуулах" захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан ажилласан. Ахмад настны цогц үнэлгээ: Хөдөлмөр,	100%	100%

	тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах;				нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийгдсэн байна.	<p>халамж үйлчилгээний газар болон Ахмадын хороонд урьдчилсан байдлаар үнэлгээнд хамрагдсан 785 ахмадын мэдээллийг хүргүүлсэн. 29 багийн 785 ахмадын түвшин 1-491 (62.5%), түвшин 2-256 (32.6%), түвшин 3-38 (4.9%) байв. Ахмад настны цогц үнэлгээ эрүүл мэндийн байгууллагуудад үргэлжлэн хийгдэж байна.</p> <p><u>Ахмад настны эрүүл мэндийг дэмжих, хамгаалах бусад үйл ажиллагаа:</u> Орхон аймагт бүртгэлтэй 13312 ахмад амьдарч буйгаас анхан шатны эрүүл мэндийн байгууллага, БОЭТ-ийн ахмадын кабинетаар 8269 ахмад (62%) урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж, 757 ахмад өдрийн эмчилгээнд, 2504 ахмад уламжлалт, сэргээн засах тусламж үйлчилгээнд, 861 ахмад анхан шатны эрүүл мэндийн байгууллагын чийрэгжүүлэлтийн танхимаар үйлчлүүлж, 10027 ахмад хөнгөлөлттэй эм бичүүлсэн байна.</p> <p>Эрүүл мэндийн байгууллагууд Ахмад настны урьдчилан сэргийлэх үзлэгийг нарийн мэргэжлийн эмч нартай хамтран зохион байгуулж (HBV, HCV, хавдрын маркер, томуугийн дархлаажуулалт, аминдэмийн багц түгээх) зэрэг үйл ажиллагааг зохион байгуулав.</p> <p>Түүнчлэн сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд эрүүл насжилтыг дэмжих (Ахмад настны хооллолтын гэр зөвлөмж, хөдөлгөөний ач холбогдол, олон эмийн хэрэглээг зохицуулах нь) зэрэг сургалтыг тогтмол зохион байгуулж байна.</p>		
3.3.5.6.	Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлж	Орон нутгийн төсвийн	1.Орон нутгийн мэргэжлийн	-	Ахмад настанд үзүүлэх цогц	Ахмад настны цогц үнэлгээ хийх тухай мэдлэг сэргээх сургалт: ЭМС-ын 2024 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан	100%	100%

	байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулж, хяналт тавих;	хөрөнгөөр	хамтарсан багийг байгуулсан эсэх 2.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийн тайлангийн тоо		тусламж, үйлчилгээ тогтмолжиж сайжирсан байна.	ICOPE үнэлгээг хэрхэн хийх тухай сургалтыг өмнөх сургалтуудад хамрагдаагүй сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 9 байгууллагын 35 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зохион байгуулсан. Мөн ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд ICOPE үнэлгээний сургагч багш Г.Мэндхүү анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд давтан сургалтыг зохион байгуулж эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулсан. "Хөвсгөл хамгаалал" НҮТББ-аас асаргаа сувилгааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй байгаагаа уламжилж, хамтран ажиллах саналыг ирүүлснийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, ХХҮГ-ын дэргэдэх Ахмадын амралт сувиллыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ажиллах ахмад настны асаргаа, сувилгааны төв болгон өөрчлөн зохион байгуулахаар шийдвэрлэж, холбогдох захирамжийг гаргасан. Ингэснээр 2026 оноос хуулийн хэрэгжилт болон бодлогын бичиг баримтад тусгагдсан дээрх ажлууд хэрэгжих боломж нөхцөл бүрдсэн.		
3.3.5.7.	Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулах, ахмад	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Бүх шатны боловсролын байгууллагад сургалт хийсэн ахмад настны тоо 2.Ажиллаж байсан байгууллагад аа	-	Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг	-Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдах хүсэлт ирүүлсэн 17 байгууллагын 39 ахмад настантай гэрээ байгуулан ажилласан. Үүнээс 26 иргэн гэрээгээ дүгнүүлж 28.0 сая төгрөгийн урамшуулал олгосон. 13 ахмадын гэрээний хугацаа 12 сард дуусаж гэрээгээ дүгнүүлнэ. -Ахмадын хороо, Төрийн бус байгууллагын зөвлөх үйлчилгээнд 11 байгууллага хүсэлтээ ирүүлснээс	100%	100%

	настныг ажиллаж байсан байгууллага болон бүх шатны боловсролын байгууллагад сар бүр сургалт хийлгэх, ахлах ангийн сурагч, оюутнуудыг ахмад настанд технологийн, цахим орчин, цахим үйлчилгээний сургалт явуулах зэрэг сайн дурын ажилд татан оролцуулах, урамшуулах;		сургалт хийсэн ахмад настны тоо		зохион байгуулсан байна.	шаардлага хангасан ахмад настны хууль эрх зүй, боловсрол, инженер техникийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ өгөх 7 ТББ-тай 197.9 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж байгаагаас 9.7 сая төгрөгийн эхний санхүүжилтийг олгосон. -Хүүхдийн эрхийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хүрээнд хүүхэд хамгаалагчаар Цагдаагийн газраас гарсан 2 ахмад настантай гэрээ байгуулан ажиллаж 3 сарын урамшуулал 3.8 сая төгрөгийг олгосон.		
3.3.5.8.	Ганц бие орон гэргүй, эсхүл түр байрлуулах газарт байсан иргэн нас барсан, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн нас барсан бол оршуулах үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Журам баталсан эсэх 2.Оршуулах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ /сая төг/	-	-Журмыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан байна. -Ганц бие орон гэргүй ахмад настанд үзүүлэх үйлчилгээ сайжирсан байна.	2025 оны байдлаар ганц бие ахмад 62, огт орон гэргүй 8 ахмад бүртгэлтэй байна. Энэ онд халамжийн тэтгэвэртэй 7 хүн нас барж хуулийн дагуу халамжийн сангаас оршуулгын зардалд 14.0 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна. Ганц бие харж хандах хүнгүй нэг ахмадыг Батсүмбэрийн Ахмадын хөгжлийн төвд, 1 хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Хөвсгөл аймгийн асрамж халамжийн төвд тус тус шийдвэр гарган хүргүүлсэн.	70%	70%

	журмыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлэх;							
3.3.5.9.	Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заасан “Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэй ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна” гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулж ажиллах, хяналт тавих;	-	50-иас дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн дагуу ажиллах ёстой ахмад настны тоо, үүнээс ажиллаж байгаа ахмад настны тоо	Суурь түвшний тоо	Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4 дэх хэсгийн хэрэгжилт хангагдаж ахмадуудын хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.	Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4 дэх хэсэг “Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэй ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна” гэсэн заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн 172 байгууллагад судалгаа хүргүүлсэн. Судалгаа ирүүлсэн 69 байгууллагад 6010 хүн ажиллаж байгаагаас ахмад настан 140 иргэн ажиллаж байна. Ажиллуулбал зохих 5 байгууллага 38 ахмад настныг ажиллуулаагүй байна. Хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор мэдээллийг тус 5 байгууллагад хүргүүлж ажиллаж байна.	70%	92.8%
3.3.5.10.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын	Орон нутгийн төстийн	1.Тухайн жилийн татвар ногдох	-	Аж ахуйн нэгжийн орлогын	Тайлант онд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамжийн үйлчилгээ, тэдгээрийн	-	-

	<p>тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах.</p>	<p>хөрөнгөөр</p>	<p>орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо 2.Зарцуулсан хөрөнгийн хэмжээ/сая.төг/</p>		<p>албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилт хангагдсан байна.</p>	<p>эрхийг хангах, хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохируулгат орчин бүрдүүлэх, хүүхдийн тоглоомын талбай, зуслан, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах, ашиглах хүсэлт ирүүлээгүй байна.</p>			
<b>ДУНДАЖ ХУВЬ</b>									<b>94.2</b>

Тайлан гаргасан:

Орхон аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн  
ахлах мэргэжилтэн

Г.Эрдэнэбулган

ХШҮ хийсэн:

Орхон аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний  
хэлтсийн дарга

Ж.Баасансүрэн

